



ЭРДЭМ

СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ШИНЖИЛГЭЭ

ᠡᠷᠳᠡᠮ



ᠰᠢᠨᠵᠢᠯᠢᠭᠡᠭᠡ

Эрхэлсэн: Э.Итгэл

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ IX (№1)

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Цолмон	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Бао Ургаацэцэг	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр хэвлэх, улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар 2024

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

VOLUME IX

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(MGL)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(MGL)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(GER)
Doctor (Ph.D)	Tsolmon	(PRC)
Doctor (Ph.D)	Bao Urgaatsetseg	(PRC)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(MGL)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(PRC)
Doctor (Ph.D)	Bold. B	(JAP)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(PRC)

Edited by: Itgel. E

THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES
Printed with permission of editorial board
a quarterly journal of research
Ulaanbaatar 2024

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ГАРЧИГ

1. Л.Чулуунбаатар

АЗИЙН БӨӨ НАРЫН ХАРАНХУЙ ОРНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ.....1

2. Кань Хай Ин

МОНГОЛ ХЭЛЭН ДЭХ МОНГОЛ УТГА ЗОХИОЛЫН ТҮҮХ СУДАЛГАА ЖИЧ
ТҮҮХ БИЧЛЭГИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ.....6

3. Ван Ин

ХАЙР ДУРЛАЛЫН МӨНХИЙН ДУУЛАЛ.....26

4. Б.Туяа

П.ХОРЛООГИЙН СУРГАН ХҮМҮҮЖЛИЙН ҮЗЭЛ САНАА БҮХИЙ ТАЙЗ,
ДЭЛГЭЦИЙН БҮТЭЭЛ.....36

5. Ашихан

БҮРЭГ СУРАЛЦАГЧДЫН ХЭЛНИЙ ХАРИЛЦААНЫ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
НЬ.....57

6. Ань Нин

ЧИН УЛСЫН ДУНД ҮЕИЙН ХӨВӨӨТ ШАРЫН СҮРЭГ БА ЦАХАР ХӨВӨӨТ ШАР
ХОШУУНЫ НУТГИЙН ХИЛИЙН ШИНЖЛЭЛ.....67



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

CONTENT

1. Chuluunbaatar. L

Asian Shaman's concept of the darkness land

2. Kan Hai Ying

On historical research and historical writing of Mongolian literature
in Mongolian language

3. Wang Ying

Eternal love song

4. Tuya. B

P. Horloo's stage and screen work with educational ideas

5. Asiheng

Enhancing communicative language teaching for quiet students

6. An Ning

The study on the boundary of bordered Yellow banner pasture and
Chahar bordered yellow banner in the middle of Qing dynasty



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭГЧИЙН ҮГ

Энэ удаагийн дугаарт Монголын Үндэсний Их Сургууль, Өвөр Монголын Их Сургууль - Монгол Судлалын Дээд Сургууль, Хаалган хот дахь Удирдлагын Сургууль, Хө Тао Дээд Сургууль зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэмтэн багш, докторант, магистрантуудын өгүүлүүд багтав. Эрдэм шинжилгээний үйл хэргийг чин сэтгэлээсээ дэмжин, зөвлөгөө шүүмжээ харамгүй хайрладаг номын садан, нөхөддөө ихэд баярлаж байна. Аливаа судалгааны ажил бүхнийг хүч хөдөлмөр, хөрөнгө санхүүгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Тус дугаарыг хэвлүүлэхэд онцгойлон дэмжлэг үзүүлсэн эрхэм анд С.Баярхүүд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Өвөр Монголын Их Сургуулийн докторант

Эрдэнэхуягийн Итгэл

2024 оны 3 сар

НОМЫН ЦАГААН БУЯН ДЭЛГЭРЭГ



АЗИЙН БӨӨ НАРЫН ХАРАНХУЙ ОРНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Л.Чулуунбаатар*

Азийн бөө нарын дунд харанхуйн орон буюу бөөгийн онгодоороо очдог орны тухай ойлголт байдаг. Эрт цагаас Азийн ард түмэн үхэгсэдийн сүнс тэнгэрт халин оддог хэмээн үзэх бөгөөд талийгаачийн хэрэглэж байсан хувцас юмс, гоёл чимэглэлийг шатаан үддэг ёс нийтлэг байна. Энэ нь түүний амьд ахуйдаа хэрэглэж байсан эд юмсын сүнсийг галын утаагаар тэнгэрт дэгдээж байгаа зан үйл юм.¹ Одоо ч гэсэн монгол үндэсний бөө нар өвгөдийн онгод шүтээндээ тахил өргөхдөө бүхэл хонины шүүсийг шатаан өргөх зан үйл үйлчилсээр байна. Эрт цагаас улбаатай монгол харын бөөд нартын орон, харанхуйн орон гэсэн хоорондоо маш уялдаатай ойлголт бий.

Нартын орон нь бидний оршин буй энэ ертөнц бөгөөд харанхуйн орон нь нас барсан хүмүүсийн сүнс очдог тэнгэрийн нэгэн доод давхраа юм гэж үздэг байна. Бөө хүний сүнс энэ харанхуйн оронд очиж онгод болдог хэмээн үздэг байна. Тийм болохоор монгол хэлэнд “нас барсан” хэмээхийг хүндэтгэн хэлэхдээ “өөд боллоо”, “тэнгэрт халив”, “тэнгэр боллоо” хэмээн хэлдэг нь сүнс тэнгэрт очдог хэмээх санааг агуулж байгаа юм. XV зууны үеэс Монголд дэлгэрсэн шарын шашны нөлөө монгол бөөд тусч харанхуйн орон хэмээх ойлголтод ч өөрчлөлт орсон байна. Бөө нар онгодоо дуудахдаа “дээд тэнгэрээс нижигнэнхэн буудаг хайрхад, дэвжид лусаас цухалзанхан гардаг хайрхад”² хэмээн дууддаг. Эндээс харахад сүнс онгодын орших орон дээр ч байна, доор ч байна хэмээн ойлгож болно. Сүнс онгодын орших дээр, доор хоёр ертөнц байвал амьд хүмүүс бидний орших нарт ертөнц гэж бас байх бөгөөд шарын нөлөө орсон бөөд гурван ертөнц хэмээх ойлголт бий болжээ.

* МҮИС-ийн доктор, профессор

¹ О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, УБ., 1999, х 109

² О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, УБ., 1999, х 112



THE CULTURAL WAY

Судлаач Ч.Далай³, Х.Буянбат⁴ нар “дунд ба доод ертөнцийн хооронд үл мэдэгдэх ертөнц бий бөгөөд хүмүүс үхэхээр голдуу энэ ертөнцөд очно” хэмээсэн байна. Тэгвэл судлаач Ёнсог “сүнс дээр, дунд, доор ертөнцийн доор ертөнцөд очдог” хэмээн тайлбарлаад энэхүү доод ертөнцийг харанхуйн орон болно хэмээсэн байна. Энэ нь тамын орны тухай бурхны шашны ойлголттой дөхөж очиж байгаа юм.

Сибирийн бөө нарын дунд ч гурван ертөнцийн тухай ойлголт байдгийг бөө судлаач Элиде⁵ 1974 онд бичсэн “Бөөгийн шашин” номдоо бичсэн байдаг.

Харин дархад бөө нарын дунд гурван ертөнцийн тухай ойлголт бараг байхгүй бөгөөд энэ нь бурхны шашны нөлөө бага орсон хийгээд хоёрт зах хязгаар нутагт хуучны уламжлал ойлголтоо хадгалсаар өдий хүрсэнтэй холбон үзэх хэрэгтэй. Бернийн Их Сургуулийн докторант Жүдит Хангартнерийн дархадын удган Умбаанар зуруулсан харанхуйн орны дээрх




Figure 3: Umban's drawing of a shamanic landscape (20.6. 2003).

зургаас тод харагдана.

Эрдэмтэн О.Пүрэвийн бичсэнээр Чойн Долгор удган онгод орох гэгчийг тайлбарлахдаа “онгодоо дуудаж байтал ямар нэг үл үзэгдэгч хий юм гэнэт тэврээд авах шиг болсноос хойш бие гэдэг хачин сайхан хөнгөн болоод л гэрээсээ гараад хатиралтай сайн морь унаад явчих шиг болдог юм. Тэгээд л алсад цэнхэрлэн харагдах их уулсын наана униар татсан их хөндийгөөр давхиж явтал урдаас хан буурал аав, хатан буурал ээж болон лусын эзэд нэг нэгээр угтан ирээд уулздаг. Тэгэхээр л ухаан алдчихдаг юм даа онгодууд

³ Ч.Далай, Монгол бөөгийн товч түүх, УБ., 1959, х 42

⁴ Х.Буянбат, Монголын бөөгийн шашны учир, Өвөрмонгол, 1985, х 86

⁵ Elide, Mirsea, Shamanism, Archaic Techniques of Ecstasy, 1974, Princeton, University Press



THE CULTURAL WAY

ирснээс хойш юу ярьж, ямар байдалтай байсныгаа огт мэддэггүй”⁶ хэмээсэн байна. “Алсад цэнхэрлэн харагдах их уулсын наана униар татсан их хөндий” хэмээн хэлж байгаа нь хэдийгээр харанхуйн орноо хэлж байвч манай энэ ертөнцтэй адил дүр зураг бууж байна. Английн эрдэмтэн Хампри “Shamans and elders” хэмээх номдоо “Дээд дунд доод гурван ертөнцөс бүрдэнэ хэмээх гурван ертөнцийн тухай ойлголт хойт Азийн ард түмнүүдийн зохиол бүтээлд байнга тааралддаг One often meets in the literature the idea that the peoples of North Asia think in terms of a tripartite cosmos, consisting of an upper world (the sky), a middle world (the earth), and an underworld”.⁷ XX зууны эхэн үеийн Дагуурын бөө нарын гурван ертөнцийн ойлголтод тулгуурлан сайн хүмүүсийн сүнс тэнгэрийн оронд муу хүмүүсийн сүнс доод ертөнцөд бас зарим нь манай энэ ертөнцөд эргэж ирдэг хэмээн бичсэн байна. Эрдэмтэн Г.Д.Санжеев⁸ 1927 онд бичсэн номдоо XX зууны эхэн үеийн буриадуудад гурван ертөнцийн ойлголт байгаагүй хэмээн дурдсан байна. Оросын эрдэмтэн Б.Дорж энэ талаар бас дурдаагүй. Германы эрдэмтэн Хайсег бичихдээ бурхны шашны нөлөө бөөд орохоос өмнө гурван ертөнцийн тухай ойлголт байгаагүй хэмээн тайлбарлаж байна.

1920 иод оны үед Н.Поппе⁹ дагуур нарын сонирхолтой үлгэрийг тэмдэглэн авсан байдаг. Түүнд Их Юань улсын үед нэг залуу гол өгсөж явсаар агуйн амаар орж шал өөр ертөнцөд аялсан бөгөөд тэр ертөнцийн хүмүүс хүний ертөнцийг орхисноос хойш бид энд хэдэн мянган жил болж байна хэмээсэн гэж бичсэн байдаг. Энэ үлгэр АНУ-ын нэрт бөө судлаач Майкл Харнерийн¹⁰ доод ертөнцөд аялсан ойголттой адилавартай байгаа бөгөөд өөр ертөнцөд аялахын тулд агуй, модны нүд, хаалга зэрэг нүхтэй олон зүйлийг ашиглаж болно гэсэнтэй орох арга нь адил байна. Тэгж аялахдаа луутай уулзсан хэмээсэн байдаг. Монголын Сайхантуяа удган “би харанхуйн оронд аялж явахдаа луутай таарсан” хэмээн хуучилсан нь М.Харнерийн үгийг баталгаажуулж байна. Бурхны шашны нөлөө бага орсон Якутын бөө нарт

⁶ О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, УБ., 1999, х 113

⁷ Caroline Humphrey with Urgunge Onon, “Shamans and elders”, Oxford, 2003, p 119

⁸ Sanjeev Garma D, 1930, The Darhad, Leningrad, Izdatelstvo Akademii Nauk SSSR

⁹ Poppe N.N, 1930, Dagurskoye Narechiye (The Dagur Dialect), Leningrad, Izdatelstvo Akademii Nauk SSSR

¹⁰ Michael Harner, The Way of the Shaman, Harper One, 1990



THE CULTURAL WAY

гурван ертөнцийн тухай ойлголт ¹¹ байдаг нь харанхуйн орны тухай ойлголтыг будлиантуулж байна.




Fig. 218. Chukchee Sketch representing the Sky and the Lower Worlds.

Гэвч сүнс онгодоор аялан очиж болдог бас тэндээс сүнс онгодыг ирүүлж уулзаж болдог тийм зэргэлдээ ертөнц байна гэдэг нь баттай юм. Туршлагагүй, олон жил болоогүй бөө нар энэ ертөнцөөс онгодыг урин ирүүлж хэрэгтэй зүйлд ашигладаг байна. Харин олон жилийн туршлагатай сүнсээ жолоодох төвшинд хүрсэн бөө бол тэр оронд айлчлан очиж, тэндээс үхэгсэдийн сүнсийг буцаан авчирч амьдруулах чадалтай байна. Эрдэмтэн О.Пүрэв энэ талаар “Багш бөөгөөр харанхуйн оронд аялах замаа заалгаснаас хойш шавь бөө гурав дахь жилээс хойш харанхуйн орноор бие даан ганцаар аялах чадварыг эзэмшдэг гэдэг. Багшаар замаа заалгах эхний долоо хоног дотор онгод орсон анхны шөнөөс харанхуйн орон гэгчтэй танилцаж эхлэнэ. Энэ өдрөөс хойш улам улмаар суралцан 15 –аас дээш жил бөөлсны эцэст харанхуйн оронд их хол зайд бараг сансар хүртэл аялах чадвартай болдог. Ийм чадвартай болмогц бусдад багшлах нь сайн бөө төрүүлэх эх сурвалж юм. Тиймгүй бол шавь нь түүхий болно”¹² хэмээсэн байна.

Мин улсын үеийн Нишин удган “харанхуй газраа сүнсийг нэхэхээр одмуй, үхээрийн улсад таамаглаж одмуй, муу газраа амыг авахаар одмуй, унасан сүнсийг цөлбөн авахаар эчмүй”¹³ хэмээн бөөлж Сэргүдэй Фияангугийн сүнсийг Эрлэг номун хааныхаас аван буцаж ирэн амилуулж

¹¹ Wasldemar Jochelson, *The Yakut*, New York City, 1933, p 310-311

¹² О.Пүрэв, *Монгол бөөгийн шашны нэр томъёоны тайлбар толь*, УБ., 2003, х 209

¹³ “Нишин удганы бичиг”, Манж хэлнээс орчуулж, эх бичгийн судалгаа хийсэн Т.Отгонтуул, УБ., 2009, х 78



THE CULTURAL WAY

байна. Ингэж харанхуйн оронд зорчиж, сүнсийг нь буцаан авчирч дахин амьдруулах бөө цөөн боловч байна. Бурхны шашинд гэгээн хутгийг олсон лам хүн ийм зүйл хийж чадах бөгөөд ийм чадалтай болтлоо урт удаан хугацааны бясалгалын хөдөлмөр туулдаг шиг бөө бас олон жилийн хөдөлмөрөөр харанхуйн оронд аялах онгодын чадал суудаг байна. Нишин удганы бичигт дурдсанаар “манай тосгонд гурав, дөрвөн бөө буй. Цөм хоол мэхэлж идэх бөө нар, гагцахуу өчүүхэн архи, нэг тахиа, атга боорцог зэргээр тахил тахиж хоол бэлтгэж байх бөө нар болой”¹⁴ гэсэн нь чадалгүй хуурамч бөө бас олон байхыг хэлсэн болой. Тийм бөө одоо Монгол маш олон байна. Тэднээс харанхуйн орны тухай асуухад огт төсөөлөлгүй байдаг.

Тийм болохоор Азийн бөө нарын дунд зэргэлдээ орших ертөнц буюу харанхуйн орон гэсэн ойлголт бүгдэд нь буй бөгөөд харин түүнд очиж аялж, ид шидийн хүчийг үзүүлж чадах нь нэн ховор байна.

Summary:

Among the shamans of Asia, the concept an adjacent world or realm of darkness is common to all, but it is extremely rare to be able to travel to it exert magical powers.

НОМ ЗҮЙ

1. Х.Буянбат, Монголын бөөгийн шашны учир, Өвөрмонгол, 1985
2. Ч.Далай, Монгол бөөгийн товч түүх, УБ., 1959
3. Caroline Humphrey with Urgunge Onon, “Shamans and elders”, Oxford, 2003
4. Elide, Mirsea, Shamanism, Archaic Techniques of Ecstasy, 1974, Princeton, University Press
5. Michael Harner, The Way of the Shaman, Harper One, 1990
6. ”Нишин удганы бичиг”, Манж хэлнээс орчуулж, эх бичгийн судалгаа хийсэн Т.Отгонтуул, УБ., 2009
7. Poppe N.N, 1930, Dagurskoye Narechiye (The Dagur Dialect), Leningrad, Izdatelstvo Akademii Nauk SSSR
8. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, УБ., 1999
9. О.Пүрэв, Монгол бөөгийн шашны нэр томъёоны тайлбар толь, УБ., 2003
10. Sanjeev Garma D, 1930, The Darhad, Leningrad, Izdatelstvo Akademii Nauk SSSR
11. Wasldemar Jochelson, The Yakut, New York City, 1933

¹⁴ ”Нишин удганы бичиг”, Манж хэлнээс орчуулж, эх бичгийн судалгаа хийсэн Т.Отгонтуул, УБ., 2009, х 69



МОНГОЛ ХЭЛЭН ДЭХ МОНГОЛ УТГА ЗОХИОЛЫН ТҮҮХ СУДАЛГАА ЖИЧ
ТҮҮХ БИЧЛЭГИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Монгол үндэстний өнөөгийн утга зохиолын түүхийн сургалтын хүрээнд

Кань Хай Ин*

ХУРААНГУЙ

Утга зохиолын түүхийн үүрэг нь нэг талаар уншигч, шүүмжлэгчийн тайлбарлах, шүүмжлэх, сонирхох явцын тасралтгүй өөрчлөлтийг дүрслэх ба нөгөө талаар хамтын зохиогч хийгээд түүний төрөл зүйл, хэлний уламжлал зэрэг зохицол бүтээлийн хамтын хөгжлийн явц жич утга зохиолын дотоод бүтэц дэх зохиол бүтээлийн хөгжлийн явцыг эрж хайдаг. Тус өгүүлэлд монгол хэлэн дэх монгол утга зохиолын түүх судалгааны тухай гол бодитой сургах материал ба сурах бичгийн тухай судлал, түүх бичлэгийн арга зарчмын тухай судлал, түүх товчоон ба түүний соёлын үндэс сурвалжийн тухай судалгаа хийх гурван талаас судалгаа өрнүүлэх болно.

Түлхүүр үгс: *Монгол хэл, монгол утга зохиолын түүх судалгаа, түүх бичлэг, арга зарчим*

Утга зохиол нь хөгжлийн явцдаа ухамсартай буюу ухамсаргүйгээр соёлд гэдрэг үйлдэл үзүүлж, бүх шат үеийн соёлын эргэлт хийгээд түүний дахин цогцлолтод оролцдог. Соёл бол түүхийн шалтгаан үр дүнгийн харьцааны дунд дутагдаж болшгүй зууч болно¹. Утга зохиолын түүхийн мөн чанар нь бодит ахуй ба гоо сайхны нэгдэл мөн. Утга зохиолын түүхийн хөгжлийн явц бол сайхан цаг ба хам цагийн

* Өвөр Монголын Их Сургууль

Монгол Судлалын Дээд Сургуулийн багш, дэд профессор

Судалгааны чиглэл: *Харьцуулсан утга зохиол ба Дэлхийн утга зохиол*

¹ 唯物史观与文学史编写林继中《江海学》1994•3, 158页



THE CULTURAL WAY

нэгдэл мөн². Утга зохиолын түүх судалгаанд авч үзвэл, хүмүүсийн үйлдэл ажиллагаа бол мөн ч судалгааны гол бай болно³. Утга зохиолын түүхийн үүрэг нь нэг талаар уншигч, шүүмжлэгчийн тайлбарлах, шүүмжлэх, сонирхох явцын тасралтгүй өөрчлөлтийг дүрслэх ба нөгөө талаар хамтын зохиогч хийгээд түүний төрөл зүйл, хэлний уламжлал зэрэг зохицол бүтээлийн хамтын хөгжлийн явц жич утга зохиолын дотоод бүтэц дэх зохиол бүтээлийн хөгжлийн явцыг эрж хайдаг.

АНУ-ын Веллек нар Утга зохиолын онол гэх бүтээлдээ “Өнгөрсөн үеийн ихэнх утга зохиолын түүхийн бүтээлүүд нь нэг бол нийгэм түүх, эсвэл утга зохиолд дэлгэрүүлэн харуулсан нийгмийн үзэл санааны түүх, өөрөөр хэлбэл тэдгээр их бага ч гэсэн он дарааллын эмх цэгцээр өрөн зэрэглэсэн бодитой уран бүтээлүүдийн тухай асуудал болон үнэлэлтээ бичиж тавьсан явдал, үгүй бол шүүмжийн зохиолуудын эмхэтгэл төдий⁴ гэж хэлж болно. Монгол уран зохиолын түүх судалгаа өрнүүлж байгаа нь Чойролжав, Б.Бүрэнбэх, Сүег, Мандах, Ү.Сугараа, Н.Сайшаалт, Чулуу, Бао Сэцэн, С.Урсгал, Б.Сүх, Ринчиндорж, Оч, М.Жалифунгаа, Жинь Хай, Эрдэнэхад, Чэнь Ганлун, Хасчимэг ... нарын судалгааны өгүүллүүд нь голдуу ӨМИС-ийн ЭШС, ӨМБИС-ийн ЭШС, ӨМҮНИС-ийн ЭШС, Дундад улсын монгол судлал, Монгол хэл утга зохиол, Монголын судлал, Алтан түлхүүр ... зэрэг сэтгүүлүүдэд нийтлэгдсэн байна.

Нэг. Бодит сургах материал, сурах бичгийн тухай судлал

Өвөрмөц онцлог бүхий нэг иж монгол уран зохиолын түүх – “Мансангийн Монгол уран зохиолын түүхийн товч шүүмж, Чойролжав. ӨМҮНИСЭШС 2003.4” гэх өгүүлэлд утга зохиолын түүхийг найруулан бичсэн жолоодох үзэл санаа, агуулга бичлэгийн тиг маяг зэрэг талаар нарийн задалж, бичгийн зохиол ба аман зохиолын харьцааг зохистой тохируулсан, тиг маягийн талаар өвөрмөц онцлогтой байх жич 13 дугаар зуунаас хой боть (анги) бүрийн ард орчуулгын зохиолыг нэг бүлэг гаргаж тайлбарласан нь агуулгыг өргөн дэлгэрэнгүй болгосон ба монгол утга уран зохиолын түүхийг үечлэх талаар зуунаар үечлэх аргыг авсан боловч

² 文学史观的反思与重构许总《文学评论》1995•2, 18页

³ 唯物史观与文学史编写林继中《江海学》1994•3, 160页

⁴ (美) 勒内韦勒克奥斯汀沃伦《文学理论》江苏教育出版社 2005•8, 302页, 309页



THE CULTURAL WAY

гол төлөв цаг хугацааг тодорхойлж өгсөн нь тохиромжтой гэж нотолж, зарим дутагдлыг нь ялган гаргажээ. “Монгол эртний уран зохиолын түүхийн сурах бичгийг ерөнхийлөн өгүүлэх нь, Буяндэлгэр. Зуу-удын БДСЭШС 1992.2” гэх өгүүлэлд хоёр их сургуулийн Монголын эртний уран зохиол, Мансангийн Монголын уран зохиолын түүх, таван дээд сургуулийн Монгол уран зохиолын түүх, Жамба Линсегийн Монгол уран зохиол, Буяндэлгэрийн Монгол уран зохиолын түүх зэрэг уран зохиолын түүхийн ерөнхий онцлогийг гурван талаар хураангуйлж, тэдгээрийн үзүүлэх ач тус, нөлөө үйлдлийг нь нотлохын дагуу эндүү ташаа зүйлийг нь ялган гаргаж, хожмын хичээл хүмүүжлийн бүтээн байгуулалт дахь хоёр талын шаардлагыг дурджээ.

“Алжаалгүй аяны ганзагын дээж – Ү.Сугараагийн онол шүүмжийн түүвэр, монгол үндэсний өнөөгийн уран зохиолын судлалыг уншаад, Н.Сайшаалт. МХУЗ 2004.6” хэмээх өгүүлэлд тус түүврийн хамарсан зохиолч ба зохиол бүтээлийн хүрээ хэмжээ өргөн, агуулга баялаг бөгөөд олон талтай, ажиглалт шинжлэлт нарийн гүнзгий бөгөөд өвөрмөц шинэ үзэл дурдалтай болсон зэргийг онцолжээ. Оюунбилэгийн “Одоо үеийн монгол уран зохиолын судалгааны содон бүтээл – Ү.Сугараа профессорын Монгол үндэстний өнөөгийн уран зохиолын судлал номын тухай, МХУЗ 2004.6” хэмээх бүтээлд баялаг материал бүхий цогц үзэл голч шүүмжлэл үнэнч өртөөлөл, хариуцлагат ухамсар түүхт үйлдэл гэх гурван талаас тус номын материал өртөөлөл, үйлдлийг үнэлэн шүүмжлэв. Мөсийн “Ү.Сугараагийн шүүмжийн тухай шүүмж, МХУЗ 2004.6”-д уран шүлэглэг сэтгэхүй, урсам яруу хэллэг, уран нарийн гүн гүнзгий шүүмжийн агуулга, түүх цаг үеийн тухай бодлогошрол гэх гурван талаас Ү.Сугараагийн “Монгол үндэстний өнөөгийн уран зохиолын судлал” хэмээх номын агуулга онцлог ба судалгааны ач холбогдлыг задлан өгүүлэв.

“Монголын эртний утга зохиолын судлал дахь шинэ нэмэр Хайдав – монголын эртний утга зохиолын судлал, Сайшаал МХУЗ 1990.1” гэх өгүүлэлд Хишигтогтохын Монголын нууц товчоон, Чакравади алтан хааны тууж хийгээд эртний монголын арван утга зохиолын бүтээлийг дэлгэрэнгүй задалсан зэргийг шинжилж, зохиогчийн үзэл нотлолыг хумхи талаар задалж, хорвоо талаар системжүүлсэн гэж үзжээ. “Монгол үндэстний утга зохиолын түүх 4 боть-ийн ойлгогдохуун ба



THE CULTURAL WAY

шинжилгээний ач холбогдлыг өгүүлэх нь, С.Урсгал Монгол хэл утга зохиол 2002.2 гэх өгүүлэлд утга зохиолын түүх нь түүхэн ухааны онцгой нэгэн салаа болсны хувьд тоочилт ба үнэлэлтийг уялдуулан утга зохиолын түүхэн улирлын явцыг тодруулах чухалтай гэж үзээд, нэлээд хүчирхэг эрдэм шинжилгээний эгнээ төлөвшрөн бүрэлдсэн эрдэм шинжилгээний баялаг хуримтлууллыг илрүүлсэн, нэлээд төгөлдөр мэдлэгийн системийг цогцлоосон зэрэг талаар монгол утга зохиолын түүх шинжилгээний төгөлдөржин боловсорч байгаа жич түүний оршиж байгаа асуудлыг гурван талаар дурджээ. “Мянган оны ороо бусгааг дахин тунгааж түүхэн хүүрнэмжийн бичлэг загварыг шинэтгэн цогцлоосон нь – Рүн, Сүх, Жао Юншянь нарын Монгол үндэстний утга зохиолын түүхийн сэнхрүүллийн ач холбогдол, Бао Сэцэн МХУЗ 2002.3” гэх өгүүлэлд өнгөрсний түүхэн дутагдлыг ялган гаргаж, тус түүхийн түүхт ач холбогдлыг нь үнэлж, өгүүлэмж тоочилт нь систем журамтай, үе дараалал нь тодорхой, бүрэн бүтэн, зөв оновчтой, амьдлаг урсам байхаар зарчим болгосон зэргийг нь дурджээ.

Уламжлалт соёлын оюунлаг танилт – монгол үндэстний уран зохиолын түүхийг үнэлэх нь Загар МХУЗ 2002.2 гэх өгүүлэлд Жао Юншянь нарын голлон найруулсан монгол үндэстний утга зохиолын түүхийг өнгөрсний хэвлэсэн уран зохиолын түүхүүдтэй харьцуулан, материалын хуримтлуулал, шинжилгээний арга, зохиолч ба зохиол бүтээлийн байршуулал, судалгааны гүнзгийрэл, жам хуулийн сүвэгчлэл, онцлог шинжийн тодруулал зэрэг талаас тус бүтээлийн үнэлүүштэй тал, өвөрмөц онцлогийг өгүүлэхийн хамт анхаарууштай зүйл буюу цаашид чанаржуулан дээшлүүлэх чухалтай зүйлүүдийг зөвлөгөө болгон өгүүлжээ. Очийн “Монгол үндэстний утга зохиолын түүх бичлэг дэх аман зохиол судлалын асуудал, МХУЗ 2002.2” гэх өгүүлэлд, Монгол үндэстний утга зохиолын түүх 4 боть-ийг өнгөрсний хэвлэгдсэн монгол уран зохиолын түүхүүдтэй харьцуулан ардын аман зохиолын судалгааны арга, түүхэн үелэлийн өвөрмөц онцлог жич түүний идэвхтэй ач холбогдол зэргийг хураангуйлан өгүүлж, тус уран зохиолын түүх бол ойрын жилийн монгол уран зохиолын түүх судалгааны томоохон амжилт болно гэж үзжээ.

“Бахархууштай бүтээл, баярлууштай амжилт – Монгол үндэстний уран зохиолын товч түүхийг уншаад, Хуулинхүү МХУЗ 1983.2” гэх



THE CULTURAL WAY

өгүүлэлд тус бүтээл нь эртний үе, орчин үе, одоо үе гэж цаг үеэр зааглаж, эртний хэсэгтээ монгол уран зохиолын гурван оргилыг нарийн задалж, Монголын нууц товчоон ба Жангарыг тус тус хэсэг хуваан өгүүлж, түүний зохиогдсон цаг хугацаанаас аваад үзэл санаа, урлагийн онцлог, дүр дүрслэл, хэл ярианд нь хүртэл олон талыг тоочсон болохоор уншигчдад гүнзгий суудал өгч, эзэмшихэд нь хялбар болгосон зэрэг онцлогийг өгүүлжээ.

“шаргаалт тунгаалт бүхий нэгэн иж орчин үеийн монгол уран зохиолын түүх – профессор Сүегийн эрхлэн найруулсан Монгол үндэстний уран зохиолын түүх, орчин, одоо үеийг уншаад, Б.Сүх Алтан түлхүүр 1998.3” гэх өгүүлэлд тус түүх нь шаргаалт тунгаалтын онцлог, утга зохиолын онолын өндөрц ба агуулгын цар хүрээг тэлсэн, хорвооч болон бичил судалгааг уялдуулсан, дээд сургуулийн хичээлийн бичгийн онцлогийг харгалзсан зэрэг онцлогийг шинжилж, 80-аад оноос нааш монгол утга зохиолын түүхэн судалгааны ойлгогдохууны талаарх хувьсал жич хойшдын судалгааны аргыг сүвэгчилжээ.

“Түүхийн үнэн хаана байна вэ? – Монгол үндэстний уран зохиолын түүх, орчин одоо үеийн тухай сэтгэгдэл, Дорногэнгэр ӨМҮНИСЭШС 1999.3” өгүүлэлд тус номын зохиогчид хорвоо судлал ба хумхи судлалыг уялдуулан, цовоо цагийн судлал ба хам цагийн судлалыг нэгдүүлсэн утга зохиолын тавцанд илэрсэн зохиолч, зохиол бүтээл, урлагийн үзэгдэл, урлагийн хөөцөлдал, үзэл ухамсрыг урлагийн дотоод жам хууль соёлын орчноос сүвэгчлэн оновчтой тайлбарлахаар чармайсан ба тус номын хошууч шинж ба олноос хэтийдсэн гэрэл гялбаа жич зөвлөх асуудлыг дурджээ. “Монгол үндэстний уран зохиолын түүхийн шинэ нээлт, Р.Ринчиндорж, Алтан түлхүүр 1998.3” өгүүлэлд тус түүх нь монгол утга зохиолын цар хүрээг тэлж, шинэ нээлт гаргасан, одоо үеийн утга зохиолын түүхэн хөгжлийг бүрэн дүүрэн шинжлэн үзүүлэх суурин дээр сүүлийн 30-аад жилийн утга зохиолын хөгжлийн явц, үзэгдэл байдал, гоо сайхны нээлт хандлага жич зохиолчдын эгнээ, бүх стилийн төлөөлөх бүтээлүүдийг хамран шинжилсэн утга зохиолын түүх зүй болон эрдэм шинжилгээний судлалын ерөнхийлсөн чанартай бүтээл болох онцлогийг хураангуйлжээ.



THE CULTURAL WAY

“Монгол үндэстний уран зохиолын түүх, одоо үеийн тухай хөөн ажиглалт, Чулуу Алтан түлхүүр 1998.3” гэх өгүүлэлд утга зохиолын түүхийн онцлог ба монгол шүлэг, тууж тус бүрийн таван талын онцлогийг хураангуйлан гаргаж, зохиогчдын гоо таашаахуйн үзэлт, урлагийн зорилт, урлагийн хүслэн гойд сайхан илэрсэн, хагас зууны монгол утга зохиолын төлөв төрөхийг шинжлэх ухаанчаар системтэй дүгнэж чадсан зэргийг шинжилжээ. Мандарваагийн “Өндөрлөгийн маань уянгат туулиан – Сүегийн эрхлэн найруулсан Монгол үндэстний уран зохиолын түүх, одоо үеийг уншаад, Алтан түлхүүр 1998.3 гэх өгүүлэлд, тус бичгийн амжилттай бөгөөд ашиглаж суралцахад амар хялбар болсон талыг ялган гаргаж, дөрвөн талаас амжилтыг нь нотолсон ба дутмаг буюу хангалттай бус зүйлийг ч дөрвөн талаар дурджээ. Сүн Шэнгүй-ийн “Үндэстний соёлын хараан дахь монгол үндэстний уран зохиол – Монгол үндэстний уран зохиолын түүхийг үнэлэх нь, ӨМНШУ 2001.4” гэх өгүүлэлд бий.

“Манай улсын монгол үндэстний одоо үеийн утга зохиолын хөгжлийн түүх – Дундад улсын монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүхийн тухай үнэлэмж, Жаргал Монголын судлал 1990.1” гэх өгүүлэлд тус түүх нь хувьсангуй бусдач үзэл ба түүхийн бусдач үзэл ба түүхийн бусдач үзлээр улс байгуулагдсанаас нааш монгол үндэстний утга зохиолын хөгжлийн түүхийг эргэцүүлэн дүгнэж, 17 жил ба шинэ цаг үеийн монгол утга зохиолын амжилт бүтээмжийг үнэлэн нотолж, 10 жилийн самуурлын монгол утга зохиолын үйлсэд авч ирсэн хор хөнөөлийг ялган гаргахын хамт хорвоо судлал ба хумхи шинжлэлийг уялдуулж, таван талын онцлогийг судалж эцэст хоёр талын дутагдал ба гурван талын зөвдөх асуудлыг дурджээ.

Эрдэнэхадын “Монгол уран зохиолын хөгжлийн товчоо номын шүүмж МХУЗ 1998.4” гэх өгүүлэлд сэтгэхүйн чиглэл байрын эзэмдлийн талаар хөгжилтийн онолын талаас төрөлжүүлсэн ажиглалтын талаар уран зохиолыг соёл төрөлжүүлж ажиглах нь адил бус төрөл зүйлийн зохиолын адил бус соёлын үндсийг сурвалжилсан талаар үнэлүүштэй сайн амжилт гаргажээ гэж гурван талаас үнэлэлт өгчээ. Чэнь Ганлун-ий Монгол уран зохиолын хөгжлийн учир зүй гэх номын тухай шүүмж МХУЗ 1996.1” өгүүлэлд бүх номд монгол утга зохиолын хөгжил бүрэлдлийн тухай зохиогчийн шинэ үзэл санаа онцлогдож, өнгөрсний



THE CULTURAL WAY

монгол утга зохиолын түүх судлалын хуучин замыг зоригтой давж, шинийг эрэлхийлэх зориг санаа харагдаж байхаар барахгүй гурван талын давуу талыг үнэлж, өдий төдий мадагтай асуудал оршиж байна гэж үзжээ.

Хөхбарсийн “Шургуу шамдлагын үр системт судалгааны бүтээл – монгол уран зохиолын хөгжлийн түүхийн удиртгал ӨМҮНИСЭШС 2001.3” гэх өгүүлэлд тус ном нь дорвитой бүтээлийн нэг нь болсон гэж хорвооч судалгаа ба бичил шинжилгээний аргаар хураангуйлан дүгнэж системжүүлэн өгүүлэхэд дурдсан өгүүлэл зохиол тусгай бүтээлүүд онцын үйлдэлтэй органик цогцыг бүрэлдүүлсэн ба монгол утга зохиолын түүхийг төрөлжүүлж судалсан үйлдлээр дамжиж нэгэн эмх цэгцтэй системт судалгаа болсон ба судалгааны арга барил нь голдуу өвөрмөц судалгаагаар нийтлэг судалгааг ахиулсан жич өндөр амжилтыг нь үнэлж, зарим гүйцэд биш талыг илтгэн гаргажээ. Энэ номын тухай Төмөржиний “Б.Сүхийн Монгол уран зохиолын хөгжлийн түүхийн удиртгалыг үнэлэх нь, ӨМҮНИСЭШС 2003.1” хэмээх өгүүлэл бий.

Сэцэнбатын “Ойрад монголын эртний уран зохиолын товчоог үнэлэх нь, Алтан түлхүүр 2001.2” гэх өгүүлэлд тус ном нь ойрад монголын эртний уран зохиолын тиг маяг, төрөл зүйл, зохиолч, зохиол бүтээлийг анх удаа бүх талаар системтэй эмхлэн цэгцэлж одоогийн улсын дотоод гадаадын ойрад монголын уран зохиолын судлалын ахуй байдлыг үнэн мөнөөр тусгаж, ойрад монголын утга зохиолын судлалын талаарх улсын дотоод гадаадын хамгийн шинэ үр бүтээлийг шингээн авсан жич түүний ач холбогдлыг өндөр үнэлэхийн дагуу оршиж байгаа хэм дутагдлыг ч ялган гаргажээ. Сарангэрэлийн “Ойрад монголын эртний уран зохиолын товчооны агуулгын багтаамж ба бүтцийн онцлог, ӨМНШУ 2001.2 гэх өгүүлэлд агуулгын багтаамжийн талаар ойрадуудын түүх ба уран зохиолын хос агуулга хураангуйлан агуулагдаж байгаа нь түүхийн мэдлэг ба уран зохиол сонирхлын хоёрдмол ач холбогдолтой болсон ба бүтцийн онцлогийн талаар ойрадын эртний уран зохиолын онцлог шинжийг тодруулахаар дамжин монгол утга зохиолын судалгааны нэг системийг бүрэлдүүлсэн гэж үнэлж, зарим түүхт дуунуудыг орхигдуулсан зэрэг дутагдлыг нь дурджээ. Баягуд Оюунбилэгийн “Ойрад монголчуудын эртний уран зохиолын тухай, ӨМНШУ 1999.5” гэх өгүүлэлд ойрад монголчуудын манай үндэстний утга зохиолын түүхэн дэх байр суурь, тэдний зохиож бүтээсэн Жангар



THE CULTURAL WAY

мэт баатарлаг тууль, Амарсанаагийн домог мэт түүхэн домог, Монголын Увш хунтайж мэт өгүүлэг, Галдамба баатрын домог мэт ардын дуу жич ардын дуу нь бичгийн яруу найраг болж хувирсан, Намхайжамц ба түүний шавь нарын зохиосон тод үсгийн зохиол буюу орчуулгын зохиол зэргийг авсаархан бөгөөд бодитой танилцуулжээ.

“Дундад улсын монгол үндэстний уран зохиолын түүх бичлэгт үзүүлсэн шинэ хувь нэмэр – Ойрад монголын одоо үеийн уран зохиолын түүхийг ажиглан шинжих нь, Чулуу Алтан түлхүүр 1999.3” өгүүлэлд тус түүхийг бичигчдийн түүхийн үзэлт, гоо сайхны үзэлтээр ойрад монголын утга зохиолын түүхэн хөгжлийн ул мөрийг ажиглан тунгаасан жич өнгөрсний утга зохиолын түүх бичлэгийн онцлог ба энэ түүхээс ойрад монголын яруу найргийн хөгжлийн адил бус хугацаан дахь шүлэгчдийн гоо таашаахуй, гоо сэхээрэхүй, гоо сайхны хүслэнг олж харах болно гэж үзээд, эцэст тус түүхийн дөрвөн талын онцлогийг хураангуйлжээ. Ханд-Онон “Ойрад монголын одоо үеийн уран зохиолын түүхийн тухай өгүүлэх нь, ӨМНШУ 2002.5 гэх өгүүлэлд тус ном нь 20 дугаар зууны 50-аад оноос 1992 он хүртэлх ойрад монголын утга зохиолын бий болж үүсэн хөгжсөн олон суурь, ерөнхий төлөв, зохиолчдын эгнээ жич зохиол бүтээл, өвөрмөц онцлог, хөгжлийн дотоод жам ёс, ололт алдагдлыг хураангуй тодорхойлсноороо эрдэм шинжилгээний чухал үнэ цэнтэй болсон ба зохиолч бүрийн зохиол бүтээлийнх нь өвөрмөц онцлогийг тодруулахаар оролдсон бөгөөд үнэнийг баримтлах байдлаар зохиолчдын амжилтыг нь нотлохын хамт, алдагдлыг нь бусдачаар бичсэн байна. Мөн амжилттай талыг нотолж, засах саналаа дэвшүүлжээ.

Чойдандарын “Ойрад монголын уран зохиолын судлалын зарим асуудал, Монгол хэл утга зохиол 2002.6” өгүүлэлд ойрад монголын одоо үеийн уран зохиолын түүх нь бүх ойрад (шиньжян, хөхнуур, ганьсу, алшаа)-ын монгол утга зохиолыг бүхий л цогцоор нь нэгтгэн авч хэлэлцэх судалгааны нээлтийн чанартай бүтээл болсон ба 20 дугаар зууны монгол уран зохиолын хөгжлийн түүхэн замыг бүх талаар системтэй хураангуйлан шинжилж, одоо үеийн уран зохиол хэмээх нэрийдлийн асуудал, Ойрад монголын уран зохиол – баруун цагирагийн учир баруун цагирагийн судлал болон бага цагирагуудын судлал, өндөрлөгийн утга зохиол хийгээд үндэстнүүдийн соёлын солилцоо гэх мэт хэдэн талаас задалжээ.



THE CULTURAL WAY

Т.Сайнбаярын “Хөгжин цэцэглэж байгаа дундад улсын монгол үндэстний одоо үеийн уран зохиол – дундад улсын монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүхийн оршил, Залуу зохиолч 1998.2” өгүүлэлд тус номоо дээд доод хоёр боть хувааж, улс байгуулагдсаны дараах зохиолчдын бүлгэмийг хэдэн төрөлд хуваан, монгол уран зохиолын түүхэнд зохих үйлдэл ба гавьяа зүтгэл үзүүлсэн зохиолчдыг нарийн бичиж оруулаад, монгол үндэстний уран зохиолын хөгжлийн түүхэнд зохих байр суурь хийгээд эзлэхүүнийг эзлүүлж, аман зохиолын үнэн бодит чанарыг нотолж, уран зохиолын хөгжлийн явцаар дөрвөн шат үе хуваан, улс байгуулагдсаны дараах утга зохиолын гол хөг аяс, 17 жилийн үеийн зохиол бүтээлийн хэлбэр, 11 сарын 3-ны дараах утга зохиолын эмзэг тал ба орчуулгын уран зохиолыг цухас дурдаж, хожмын уран зохиолын түүх бичих шаардлагыг дурдав, бас түүний “Дундад улсын одоо үеийн монгол утга зохиол, Алтан түлхүүр 1987.3” гэх өгүүлэл ч бий.

Ян Ёужунь-ий “Монгол үндэстний одоо үеийн уран зохиол дөчин жил – дундад улсын монгол үндэстний одоо үеийн уран зохиолын түүхийг үнэлэх нь, ӨМӨС 1989.11.30” гэх өгүүлэлд уран зохиолын түүх бол зохиогч хийгээд зохиол бүтээлээр бүрэлддэг, тус ном нь уран зохиолын цар хүрээн дэх түүхийн бодит ахуй даруй тууж, найруулал, шүлэг, жүжгээс гадна кино зохиолыг ч тусгай бүлэгт танилцуулсан давуу талыг нотолжээ. Мөн Шидэнхүүгийн “Монгол утга зохиолын судалгааны баярлуштай амжилт – дундад улсын монгол үндэстний одоо үеийн утга зохиолын түүхийн тухай товч өгүүлэх нь, ӨМӨС 1990.3.25” гэх өгүүлэлд бий.

Дээрх өгүүллүүд нь заах материал ба сурах бичгийг агууч хараагаас олон талаар системтэй үнэлэн судалж, хорвоо судлал ба хумхи шинжлэлийг уялдуулан, түүний давуу тал ба хүрэлцэхгүй тал, онцлог зэргийг бүтээлчээр хураангуйлж, монгол утга зохиолын түүх судалгаан дахь түүхт ач холбогдол, үнэ цэн, нөлөө үйлдэл зэргийг бусдачаар үнэлсэн бөгөөд хойшдын хичээл хүмүүжил, заах сургалтын бүтээн байгуулалтын талаарх шаардлага, зөвдөх асуудал, арга зарчим зэргийг сүвэгчилжээ.



THE CULTURAL WAY

Хоёр. Түүх бичлэгийн арга зарчмын тухай судлал

“Монгол уран зохиолын түүх бичлэгийн тухай бодлогошрол, Чойролжав ӨМҮНИСЭШС 2003.4” гэх өгүүлэлд утга зохиолын түүхийн ойлгогдохууны тухай, утга зохиолын түүхийн судалгааны тухай, утга зохиолын үелэл хугацааллын тухай өөрийн үзлээ дурдсан бөгөөд бичлэгийн аргын тухай, утга зохиолын түүхийг судлахдаа дотоод судлал ба гадаад судлалыг уялдуулвал зүйтэй гэжээ. Утга зохиолын түүх бичлэгт зохиол бүтээлийг голчлон судлах онцлогийг ялган гаргаж орчуулгын утга зохиолыг зүй зохистой сонгож оруулах ба утга зохиолын түүхийг хэрхэн хуваарилах асуудал жич сурах бичиг ба утга зохиолын түүхийн бодит шаардлагыг дурджээ. “Монгол уран зохиолын түүх бичлэгийн учир, Б.Бүрэнбэх ӨМИСЭШС 1999.1 гэх өгүүлэлд эхэн үеийн утга зохиолын түүх бичлэгийг дурдаж, өнгөрсний түүх бичлэгийн дутагдалтай талыг ялган гаргаж, бүрэн бүтэн утга зохиолын түүхэнд монгол хүний хятадаар бичсэн зохиол ба монгол хүний төвөдөөр бичсэн зохиолыг оруулах бөгөөд улсын гадаадын утга зохиолын түүхийн үелэлийг хяналт болгон утга зохиолын өөрийнх нь хөгжлийн онцлог болон нийгэм түүхийн хөгжил хувиралттай уялдуулан үелэх үзлээ дэвшүүлсэн бөгөөд урлагийн дотоод хараа, дотоод жам хуулийн онол ба урлагийн гадаад хараа, гадаад жам хуулийн онолыг уялдуулан монгол уран зохиолын түүх бичлэгийн тухай нэлээд системтэй онол аргаа дурджээ. “Одоо үеийн монгол уран зохиолын түүх бичлэгийн асуудалд, Мандах Алтан түлхүүр 1999.1 гэх өгүүлэлд одоо үеийн утга зохиолын түүх бичихэд зохиолчийн танилцуулга ба зохиолын задлалтаар гол болгосон уран зохиолын түүх бичихгүй, харин хөгжлийн явцыг хураангуйлан дүгнэж, жам хуулийг сүвэгчлэн хайсан түүхийг бичнэ гэж чухалчлав. Өнгөрсний түүх бичлэгт хэрхэн хандах ба хойшдын түүх бичлэгийг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг сүвэгчилжээ.

“Монгол утга зохиолын судлал дахь аргын асуудал ба шинжилгээний дүрэмжил, С.Урсгал МХУЗ 2001.6” гэх өгүүлэлд өнгөрсний монгол утга зохиолын түүх судлал бичлэгийн үндсэн байдлыг өгүүлсэн суурин дээр монгол утга зохиолын түүх зүйг цогцлох нөхцөл бололцоо хийгээд тулгам чанарыг хэдэн талаар өгүүлж, төрөгдөл маягийн судалгааны аргыг өөрчлөх хэрэгтэй болсон ба судлах ач холбогдолтой бөгөөд эрдэм шинжилгээний үнэ цэнтэй асуудлыг



THE CULTURAL WAY

илрүүлэх, өөр бусдын судалгааны үр бүтээмж зэрэг нь аливаа аргын урьдал болох ба дүрэмжлийн талаар судалгааны үнэ цэнтэй эсэхийг тодлох, шинэ материалыг уудлах, судалгааны эш баримтыг чухалчлах зэрэг асуудлыг дурдаж, монгол утга зохиол судлал дахь үнэлэлтийн дүрмийг цогцлоох тухай саналаа дэвшүүлжээ.

“Дундад улсын шинэ эрнний монгол судлалын эргэцүүлэл хийгээд тунгаалт” гэх номынхоо “Уран зохиолын түүх бичлэг” гэх хэсэгт: Адил бус баримжаа ба зарчмыг үндэслэж утга зохиолын түүх бичлэгийг хамарсан цагийн урт богины байдал, хамарсан агуулгын баялаг цөөний байдал, бичигдсэн зориулалт, хэлбэр ба онцлог шинжийг нь үндэслэж, адил бус төрөл хуваан шинжилжээ. Үүнд өнгөрсний нэвтэрхий түүх бичлэгийн дутагдлыг ялган гаргаж, үечилсэн түүх бичлэг, стиль төрөл хуваасан түүх бичлэг, орон нутгийн түүх бичлэг зэргийн амжилт ололт алдаа дутагдал зэргийг сүвэгчилжээ.

“Одоо үеийн монгол уран зохиолын түүх бичлэгийн учир, Б.Сүх ӨМҮНИСЭШС 2000.1 гэх өгүүлэлд уран зохиолын үзэгдлээр одоо үеийн монгол уран зохиолын түүх бичлэгийг бичих тухай есөн зүйлийн уран зохиолын үзэгдэл жич уран зохиолын газарзүйн талаас одоо үеийн монгол уран зохиолын түүх бичлэгийг бичих тухай нарийнг ширхэгчлэн судалжээ. Одоо үеийн монгол утга зохиолын түүх бичих тухай ойлгогдохуунаа шинэтгэж, түүх бичлэгийн хараа ба аргаа өөрчлөх чухалтай гэжээ. Бас “Монгол уран зохиолын түүх судалгаа ба түүх бичлэг, Б.Сүх МХУЗ 2001.3” гэх өгүүлэлдээ монгол уран зохиолын түүх судалгааг улсын гадаад ба улсын дотоодын түүх судалгаа ба түүх бичлэг гэж ангилж, улсын дотоодынхыг монгол хэлний заах материалын байгуулалт хийгээд монгол утга зохиолын хөгжлийн, үелэсэн утга зохиолын, төрөл стиль хуваасан утга зохиолын, орон нутгийн утга зохиолын, хятад хэлээр бичигдсэн утга зохиолын түүх судалгаа ба түүх бичлэг гэхчлэн төрөлжүүлэн задалжээ.

“Монгол уран зохиолын түүх бичлэгийн шинийг үүдгэхэд уран зохиолын түүхийн тухай онол ойлгогдохуун холбогдох нь, Б.Сүх Дундад улсын монгол судлал 2006.6” гэх өгүүлэлд нийт монгол утга зохиолын түүх бичлэгийн шинийг үүдэж гүнзгийрүүлэн хөгжүүлэх жич монгол утга зохиолын түүх бичлэгийн ухааныг судлах гэвэл дундад гадаадын



THE CULTURAL WAY

эрдэмтдээс утга зохиолын түүхийн тухай дурдсан ухагдахуун ойлгогдохуун, чухал өгүүлэмж таниварыг өргөнөөр танин эзэмших хэрэгтэй гэжээ. “Монгол цохолбор бичилт хийгээд монголчуудын түүх бичлэгийн шүүмж, Б.Сүх БХҮНИСЭШС 1994.2 гэх өгүүлэлд монгол түүх бичлэгийн тухай олон арван материалыг ашиглан, монгол үндэстний түүх бичлэгийн шүүмж, цохолборын тухай ярихдаа голдуу Рашпунцагийн Болор эрхи-ийн цохолбор бичилтээр гол болгон бүх талаар шинэчлэлт хийв. “Монгол уран зохиолын судалгааны шинэ давалтын тухай, Б.Сүх ӨМНШУ 2007.1” өгүүлэлд 21 дүгээр зуунд орсон өнөөдөр бид монгол уран зохиолын судалгааны шинэ давалтыг гаргах гэвэл, хамгийн түрүүнд монгол уран зохиолын судалгааны урьдал нөхцөл – материал, сурвалж бичгийг шинээр илрүүлэх хэрэгтэй. Дараа нь эрхбиш судалгааны сэтгэхүй, арга зүйн талаар шинийг үүдэх хэрэгтэй. Тэгвэл өнгөрсний монгол уран зохиолын судалгааны түүхийг системтэй судалж, судалгааны оноо алдаагаа сайтар дүгнэж, судалгааны шинийг үүдэх чухалтай гэжээ.

“Монгол уран зохиолын түүх бичлэгийн онол аргад холбогдох зарим асуудал, Оч ӨМБИСЭШС 1999.4” гэх өгүүлэлд өнгөрсний утга зохиолын түүхийн материалын эзэмшил сонголт ба агуулгын багтаамжийн талаар тухай цаг эриндээ нэлээд байр суурьтай, нөлөө тусгалтай зохиолч ба зохиол бүтээл орхигдон гээгдсэн буюу утга зохиолын түүхэнд орон байр эзлэхээргүй зарим зохиолч ба зохиол бүтээл сонгогдон орсон, утга зохиолын түүх бичлэгийн онол аргын талаар зарим нь энгийн задлалт, ердийн тоочилт буюу материалын танилцуулга төдий болсон эмзэг талыг ялган гаргаж, аман зохиол ба бичгийн зохиолын асуудлыг зохистой шийдвэрлэх тухай үзэлт ба хэдэн саналаа дурдсан байдаг.

“Одоо үеийн монгол уран зохиолын түүх бичихэд холбогдох хэдэн асуудал, М.Жалифунгаа ӨМНШУ 1990.3” хэмээх өгүүлэлд утга зохиолын түүхийг дөрвөн төрлийн утга зохиолын түүх хувааж, дөрвөн зүйлийн тигийн давуу тал ба дутмаг талыг хялбар задалсан суурин дээр тусгай сэдэвт тигийг одоо үеийн монгол утга зохиолын түүх бичлэгт хамгийн тохиромжтой гэж зөвтгөн өгүүлжээ. Гадаад дотоодын утга зохиолын түүхээр жишээ баримт болгон задалж, одоо үеийн утга зохиолын түүхэнд орох зохиолчдын үндэслэл баримтын тухай өөрийн



THE CULTURAL WAY

үзлээ дурдсан нь хэтэрхий хийсвэр хоосон болсон ба түүний үзэлт танилт нь бүтээлч чанараар дутмаг байж, үелэл хугацааллын тухай дэндүү өрөөсгөл үзэлт болно.

“Монгол уран зохиолын түүх бичлэгийн арга зарчмууд, Жинь Хай МХУЗ 1998.5” гэх өгүүлэлд он дараалсан түүхийн маягийн, хувьсалын онолын, соёлын түүхийн бүлэгтний Марксын үзлийн уран зохиолын түүхийн үзлээр гол болгосон нийгэм зүйн бүлэгтний, хэлбэрч үзлийн, хүртээлийн онолын, гоо сонирхлын түүх нийгэм зүйн, үндэстний соёл – сэтгэцийн хөдлөнгүй байгууламжийн суурь дээр утга зохиолын түүхэн явцыг эзэмших зэрэг аргыг бодитой шинжилж, өөрийн утга зохиолын түүхэн судалгааны загварыг шинжлэх зарчмуудыг дурдан гаргажээ. Бас “Монгол уран зохиолын үечилсэн түүх бичлэгийн оноо алдаа, Жинь Хай ӨМНШУ 2005.2” гэх өгүүлэлдээ утга зохиолын үечилсэн түүхийн ухагдахуун жич орчин үеийн үечилсэн түүх бичлэг нь онолын хувьд чухам ямар онцлог ба жам хуультай болох, эртний монгол утга зохиол нь хэрхэн орчин үеийн утга зохиолоор дамжиж одоо үеийн утга зохиол дэс шилжсэн асуудлыг тийм тодорхой шийдвэрлэж чадаагүй байсаар ба одоо үеийн монгол утга зохиолын түүх бичлэгийн хэт явцуу урлагийн ойлгогдохууны одоо үеийн монгол утга зохиолд учруулсан сөрөг нөлөөг тунгаан шийдэхийн хамт, орчин үеийн түүх бичлэгийн давшингуй тал ба хүрэлцэхгүй талыг шинжилж, одоо үеийн утга зохиолын үечилсэн түүх бичлэгийн дутагдлыг нь таван талаар хураангуйлжээ.

“Дундад улсын монгол уран зохиолын нэвтэрхий түүх бичлэгийн тоочил задлал, Жинь Хай ӨМИСЭШС 2004.4” гэх өгүүлэлд 20 дугаар зууны 70-аад оны сүүлчээс эхэлсэн дундад улсын монгол уран зохиолын нэвтэрхий түүх бичлэгийг түүхийн материал, түүхийн ойлгогдохуун, түүхийн цогцлолт зэрэг хэдэн талаас ажиглан задалж, монгол уран зохиолын түүх бичлэг амжилт олж нэлээд баялаг туршлагыг хуримтлуулсан боловч уран зохиолын ойлгогдохуун ба уран зохиолын түүхийн ойлгогдохуун нь хоцорч, бичлэгийн арга загвар нь хэвшсэн гэм дутагдал оршиж монгол уран зохиолын түүх зүйн бүрэлдэл боловсролд давалтын чанартай ахиц гарахад харшилж байна гэсэн үзэлтийг дэвшүүлэв.



THE CULTURAL WAY

Дээрх өгүүллүүд нь монгол утга зохиолын түүх бичлэгийн арга зарчим ба дүрэмжлийн тухай нарийн ширхэгчлэн хувааж, төрөл зүйл ангилан судалж, монгол түүх товчооны үндсэн жам хууль ба тогтолцоог эрэлхийлж, түүнийг хэрхэн байгуулан хөгжүүлэх үзэлт танилт ба утга зохиолын түүхийн цаг үеийг нийгэм түүхийн хөгжил хувиралтыг үндэслэн хуваарилах баримжаа, сонгогдон орох зохиолчдын баримжаа, эш баримтыг чухалчлах ба шинжлэх ухаанч үнэлэлтийн дүрмийг цогцлоон байгуулах жич утга зохиолын түүх бичих үндсэн шаардлага, найдвартай санал зөвлөгөөг дэвшүүлсэн байна.

Гурав. Түүх товчоон хийгээд түүний соёлын үндэс сурвалжийн тухай судалгаа

“Монгол хэлний түүх утга зохиол ба түүхэн өгүүлэлт, Б.Гэрэлт МХУЗ 1998.6” гэх өгүүлэлд хүн бүрийн баримталсан эш ухаан нь хоорондоо зөрөөтэй байснаас түүхэн үзлийн тогтоц нь харин ялгаа их гарчээ. Монголын удам судрын талаар адилгүй тайлбар буюу судалгааны тогтоц хоорондоо зөрөө гарсан боловч түүх бичлэг ба бичлэгийн арга барилын талаар харилцан ялгагдах ялгаа төдий гарсангүй. Түүх сурвалж бичгүүдийн утга зохиол лугаа харьцаа холбооноос авч судлах нь монголын онцгой соёлын орчин ахуйд түүний зохион бичлэгийн онцлог шинж лугаа нийцнэ. Онцгойлон монголын түүхэн бичгүүд сурвалж бичгийн чанар шалтгаан үндсэн гурвыг ангид чухалчилдаг гэж дурджээ.

“Монгол үндэстний орчин үеийн утга зохиолын түүхийн шинжилгээний салааг байгуулан хөгжүүлэх тухай бодолхийлэл, Сүег ӨМИСЭШС 2005.2” гэх өгүүлэлд орчин үеийн утга зохиолын шинжилгээ нь биеэ даасан тусгай шинжилгээний салаа болж тогтносон ба одоо үеийн утга зохиолын шинжилгээ нь улс байгуулагдахын дагууд эхэлсэн боловч Соёлын их хувьсгал дуустал системтэй судлал болж чадаагүй байсан ба өмнөх утга зохиолын түүхийн давуу тал ба хүрэлцэхгүй талыг задалж, үндсэн жам хууль болон тогтолцоо бүрэлдэж чадаагүй гэж хураангуйлан, шинэ эринд Сүег, Цэвэрхас ... нар олон талын сүвэгчлэл өрнүүлж байгаа жич оршиж байгаа асуудал хийгээд түүнийг дүрэмжүүлэх, шинжлэх ухаанчаар ажиллах дүрэм зэргийг тус тус дөрвөн талаар дурджээ.



THE CULTURAL WAY

“Орчин үеийн монгол утга зохиолын түүх судлал дахь хэдэн асуудал, С.Урсгал ӨМИСЭШС 2006.5 гэх өгүүлэлдээ орчин үеийн монгол утга зохиолын түүх судлалд оршиж байгаа сонгодог бүтээлийг эрхэмлэх утга зохиолын түүхийн ойлгогдохууныг шинэчлэх, системт судлалаар монгол утга зохиолын түүхийн хөгжлийн жам ёсыг сүвэгчлэх, материалын эмхлэл цэгцлэлээр монгол утга зохиолын түүхийн оршихуй төлвийг тодруулах, сонгодог зохиолч ба зохиол бүтээлд суурилсан утга зохиолын түүхийн хуучин хэвшлийг эвдэн монгол утга зохиолын түүхийн олон давхаргат тогтолцоог цогцлоох зэрэг хэдэн асуудлыг дурдаж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг сүвэгчилжээ. “Орчин үеийн монгол утга зохиолын судалгаан дахь асуудал хийгээд арга, С.Урсгал Монголын судлал 2006.2” гэх өгүүлэлд орчин үеийн монгол утга зохиол судалгааны материалыг уудлах ба ашиглах, ойлгогдохууныг шинэчлэх, шүүмжийн сэтгэхүйгээр асуудлыг орлуулахаар асуудлын ухамсар дутагдаж байх зэрэг шийдвэрлэх чухалтай асуудлыг дурдаж, судалгааны арга зарчмын шинжлэх ухаанч чанарыг чухалчлах бол эдгээрийг шийдвэрлэх арга болно гэдгийг ялган гаргаж, шинжлэх ухаанч үзлийг санаачлах бол орчин үеийн монгол утга зохиолын судалгаанд чухал болох арга ба ойлгогдохууны ач холбогдолтой гэжээ.

“20 дугаар зууны монгол утга зохиолын түүх зүй шинжлэлийн тухай, С.Урсгал ӨМИСЭШС 2001.2” гэх өгүүлэлд 20 дугаар зууны монгол утга зохиолын түүх бичлэгт нэгэнт нэвтэрхий түүх, үелэсэн түүх хийгээд орон нутгийн утга зохиолын түүх хэвлэгдэж, систем бүрэлдэц, туурвих сэтгэмж хийгээд тоочих хэв маяг зэрэг талаар үндсэндээ цаг үе – зохиолч – зохиол бүтээл – агуулга үзэл санаа – урлагийн онцлог гэх хэвшлийг бүрэлдүүлж, зохиогч – зохиол бүтээлийн загварыг эрхэмлэдэг нь тэдгээрийн нийтлэг хэлбэрэл болох ба материалын хуримтлуулал, оюуны бэлтгэл, шинжилгээний хандлага, танилт хэлбийх, ойлгогдохуун балархай зэрэг шалтгаанаас болсон нөхцөл бололцоо хийгээд тулгам чанарыг ялган гарган монгол утга зохиолын түүх зүй шинжлэлийн ерөнхий харалтыг ялган гаргажээ. “20 дугаар зууны монгол утга зохиолын түүхэн дэх хэдэн асуудал, С.Урсгал МХУЗ 2001.5” гэх өгүүлэлдээ монгол утга зохиолын түүх нь голдуу хятад хэлээр бичигдсэн монгол уран зохиолын түүх болж байгаа хачин үзмэр хийгээд тууж бүтээлийн боловсрол дутмаг, урлаг шаргаалтын тэвчээр дутмаг, монгол уран зохиолын түүхэнд монгол роман цөөн байгаа зэрэг асуудлыг



THE CULTURAL WAY

дурджээ. Бас “20 дугаар зууны монгол утга зохиолын түүх судлалын хөгжлийн шат үеийг өгүүлэх нь, С.Урсгал ӨМИСЭШС 2007.4” өгүүлэлд монгол утга зохиолын түүхчилсэн судалгааны жаран жилийн хөгжлийг түүний онцлогийг үндэслэн, үүслийн шат ба боловсролын шат гэхчлэн ангилж, сүүлчийн шатыг бас анхан шат, хоёр дахь шат ба олон эшчиллийн хөгжлийн шат болгон нарийсаж, эдгээр шат үе нэг бүр нь тухайн монгол утга зохиолын түүх судалгааны түвшинг харуулж, адил бус онцлогийг бүрэлдүүлэв гэж агууч хараагаар шинжилжээ.

“Монгол орчуулгын утга зохиолын түүх жич холбогдол бүхий асуудал, С.Урсгал ӨМИСЭШС 1999.4” өгүүлэлд монгол утга зохиолын түүх зүй хэмээх тусгай шинжилгээг санаачилж болох бусдач нөхцлийг задалж, орчуулгын утга зохиолын ухагдахуун, байр суурь хөгжлийн хандлагыг өгүүлж, тус зууны монгол утга зохиолын түүх бичлэгийн онол ба үйлдлийн урьдалд монгол орчуулгын утга зохиолын түүхийг шинжлэх нь монгол утга зохиолын түүх зүйг цогцлоох чухал явц мөн гэх үзлийг дурдан гаргав. “Монгол үндэстний орчуулгын уран зохиолын түүх судлалын шинжилгээ, С.Урсгал ӨМБИСЭШС 2003.3” гэх өгүүлэл нь орчуулгын утга зохиолын дурдалт ба холбогдох асуудал, утга зохиолын хараан дахь орчуулгын утга зохиол, дүгнэлт гэх гурван талаас судалж, орчуулгын утга зохиолын түүх шинжлэлийн долоон талын онцлогийг хураангуйлан гаргажээ.

“Монгол түүх товчооны уран зохиолын үзэгдлийн соёлын үндэс, Б.Сүх МХУЗ 1993.4” гэх өгүүлэлд монгол түүх товчооны утга зохиолын хөгжил нь монголчуудын дээдсийн шүтлэгийн соёлд үндэслэгдэж байх ба хүмүүсийн түүхэн ухамсрын бий болсон нь түүний өөр би-ийн ухамсрын сэхээрцийг харуулахын хамт хүн төрөлхтний тасралтгүй сэхээрхийг ахиулах, монгол түүх товчооны утга зохиолын үзэгдэл хийгээд монголчуудын үлгэр түүх сонирхох гоо таашаахуй удамшил зэргийг судалжээ. “Монгол уран зохиол хийгээд харь бусад уран зохиолын холбоо, Б.Сүх МХУЗ 1993.4 гэх өгүүлэлдээ монгол шилжүүлмэл дуураймал зохиолын үзэгдэл, монгол утга зохиолын стилийн баялагжилын үзэгдэл зэргийг задалж, утга зохиолын хөгжил нь голт хөгжил ба хөндлөн хөгжил гэх хоёр талыг багтааж, монгол утга зохиол хийгээд харь бусад утга зохиолын харьцаа холбоог олтгойлж



THE CULTURAL WAY

болшгүй ач холбогдолтой гэж монгол утга зохиолын хөгжлийн түүх ба онол, үйлдлийн талаар баттай хариулт өгчээ.

М.Жалифунгаан “Одоо үеийн монгол утга зохиолын хөгжлийн тухай тоймчилсон ажиглалт, Алтан түлхүүр 1987.2” гэх өгүүлэлд одоо үеийн утга зохиолыг нийгэм, улс төрийн хөгжил хувиралд агуулга үзэл санааг нөлөөлөгдсөн байдал ба тус биеийнх нь хөгжлийн онцлогоор үндэслэл болгож, бүтээн байгуулалтын шат үе (төвшрөлийн үе ба бүтээн байгуулалтын үе), хоосролын шат үе, шинэ цаг үеийн утга зохиолын шат үе (шинэ эриний монгол шүлэг, туужийн зохиол, найруулал) гэж гурван шат үеэр хуваан задалсан байна.

Дээрх өгүүллүүд нь монгол утга зохиолын түүх товчооны үндсэн жам хууль ба тогтолцоог эрэлхийлж, монгол утга зохиолын түүх бичлэг дэх монгол утга зохиол хийгээд өөр бусад утга зохиолын харьцаа холбоо жич нөлөө тусгал зэргийг хорвооч талаас харьцуулан судалж, монгол утга зохиолын түүх товчооны утга зохиолын үзэгдлийн үндэс сурвалж, цаашлаад соёлын агуулагдахуун зэргийг ухчилсан нь монгол утга зохиолын түүх судалгааны нэн гүн ахисан гэдгийг харуулжээ.

Үүнээс гадна утга зохиолын түүхийг хэрхэн хугацаалах тухай судалгаа бас өрнөж байна. Сугараагийн “Монгол үндэстний орчин үеийн уран зохиолын судлал дахь зарим асуудал, ӨМБИСЭШС 1991.3” гэх өгүүлэлд орчин үеийн утга зохиолын түүхэн үелэлийн тухай Содбилэг, Эрдэнэтогтох, Тогтом, Н.Сайшаалт, Чимэддорж, Хасчимэг, С.Өлзийбат нарын ном дахь орчин үеийн монгол утга зохиолын түүхэн үелэлийг задалж, 1921-1949 он гэх хугацааллыг дурджээ. Хасчимэгийн “Монгол үндэстний уран зохиолын түүхийн орчин үеийн хугацааллын тухай бодолхийлэл, ЗУБДСЭШС 1999.1” өгүүлэлд монгол утга зохиолын орчин үеийн хугацааллыг адил бус дөрвөн зүйлээр тэмдэглэж байх нь хугацааллын хэмжээ нэгдэлгүй, хугацааллын цаг дэндүү богино, хугацааллын баримжаалал тохиромжгүй гэж дурдсан ба өгүүлэлд ойр орчин үеийг нэгтгэж, 1840-1949 оноор үечилж орчин үе хэмээн нэрлэвэл зохимжтой гэх үзлээ дурдаж, ингэж хугацаалах нь цаг ба түүх ахуй, утга зохиолын хөгжил аль ч талаар үзсэн нь тохиромжтой гэжээ.

“Ойрад монгол уран зохиолын Товчоо, Түүх-ээс үүсгэн өгүүлэх нь – Баянтын асуултын хариу, П.Дамбийпэлжид МХУЗ 2001.6” гэх



THE CULTURAL WAY

сурвалжилгад ойрын жил хэвлэгдсэн ойрад монгол уран зохиолын Товчоо, Түүх хэмээх хоёр ном бичигдсэн явц, алдаа оноо ба ойрад монгол уран зохиолын одоогийн байдал зэрэг асуудлыг ярилцжээ. Түүний “Орчин үеийн монгол уран зохиолын түүхэн хугацааллыг ангилах тухай сүрхий шүүрхий санал, Ул ба зул 1993”, түүхийн сэдэвлэхүүний цээрийг тайлаасай – түүхэн уран зохиолыг хөгжүүлэх тухай зөвлөгөө, Ул ба зул ШАХХ 1993, Т.Сайнбаяр “Ойрад монголын одоо үеийн уран зохиолын түүхийг дөхөм өгүүлэх нь, Ойрад судлал 2000.1” гэх өгүүлэл бий.

М.Жалифунгаан “Монгол уран зохиолын түүхийн цаг үеийг хэрхэн хуваарилах тухай өгүүлэх нь, ӨМНШУ 1999.6” гэх өгүүлэлд үндэстний утга зохиолын хөгжлийн цаг үеийн хуваарилал нь заавал тэр үндэстний нийгмийн хөгжлийн түүх, соёлын хувирал хөгжлийн бодит байдал, утга зохиолын хөгжлийн бодит байдал гэх гурван чухал үндэслэлээ чанга баримтлах хэрэгтэй. Одоогийн монгол уран зохиолын түүх нь бүр дундад улсын уран зохиолын түүхийг дуурайн эрт үе, орчин үе, ойр үе гэж дөрвөн шат үе хуваарилсан нь монгол уран зохиолын түүхийн хөгжлийн цаг үеийн бодит байдалд зохицохгүй юм гэж түүний учир шалтгааныг бодитойгоор өгүүлэн нотлов.

“Утга зохиолын түүхийн асуудал бол мөн чанартаа утга зохиолын ойлгогдохууны асуудал мөн, даруй ямар янзын ойлгогдохуунтай бол тиймэрхүү утга зохиолын түүх бичлэг бий болдог. Түүхийн үзэлт нь утга зохиолын түүхийн үзлийг төлөөлж чадахгүй байж, нэн ч утга зохиолын түүх бичлэгийн үйлдэлтэй тэнцэхгүй байдаг”⁵.

Утга зохиолын түүх бол зохиогч, зохиол бүтээл болон уншигчийн хоорондох харьцааны түүх мөн. “Утга зохиолын түүхийг дахин бичихийн гүн гүнзгий асуудал бол голдуу гадаад оршихуйн эрдэм шинжилгээний орчин тойрныг түшиглэх биш, харин хүмүүсийн дотоод мөн чанарын хүчин чадлын хувьсал, даруй утга зохиолын түүхийн судалгаа нь бодгаль бие, түүхийн сэтгэхүйн загварын өөрчлөлт хийгээд дахин цогцлолтыг судалдаг”⁶. Иймээс утга зохиолын түүх бичлэгт утга

⁵ 唯物史观与文学史编写林继中《江海学》1994·3, 161页

⁶ 略论文学史研究中的文化意识汤漳平《社会科学辑刊》1995·1, 156页



THE CULTURAL WAY

зохиолын өөрийнх нь хөгжлийн судлал жич утга зохиолын жам ёсны сүвэгчлэлийг хөнгөвчилж болохгүй.

“Утга зохиолын түүхийн судлалын тухай судлал болох шинжилгээ – утга зохиолын түүх зүй нь утга зохиолын түүхийн судлалын тус биеийг судлах онцгой нэгэн шинжилгээний салаа мөн. Шинэ эриний утга зохиолын түүх судлал нь өнгөрсний хялбархан нийгэм зүй, улс төрийн ухааны судлалын аргыг эвдэж, шинжилгээний салаа сундалсан судалганы арга даруй археологи судлал, домог зүй судлал, хүн зүй судлал, сэтгэц судлал, үндэстний судлал, гоо зүй судлал, хэл зүй судлал ... зэрэг аливаа ашигтай судалгааны арга ба онолыг шинжилгээний үйлдэл дундаа ашиглаж чаджээ⁷.

Утга зохиолын түүх судалгааны шинэ үзэлт, шинэ сэтгэхүйн бүрэлдэл, утга зохиолын түүхийн бүтээлийн шинэ байгууламж, шинэ байршууллын бүтээн байгуулалт зэрэг нь яриангүй чухал ач холбогдолтой. Утга зохиолын түүхийн чанар чансаа, хэр хэмжээг батлах чухал элементийн нэг бол утга зохиолын түүхийн ойлгогдохууны харьяалагдах чанар хийгээд түүний бодгаль чанар болно. Энэ бол шинжлэх ухаанч утга зохиолын түүхийн үзэлтийн амь нас ба амин сүнс мөн. Утга зохиолын түүх тууригчдын бодгаль чанар нь голдуу түүхийн уг дүрсийг хүндэтгэсэн суурин дээр, утга зохиолын түүхийг бүрэлдүүлсэн олон зүйлийн элемент – үзэл урсгал, хөдөлгөөн, нийгэмлэг, урсгал бүлэг, утга зохиолын шүүмжлэл, зохиогчийн зохиол бүтээл жич харьцаа холбоо зэрэгт нарийн хянамгай сонголт хийх ба гүн гүнзгий илчлэл хийх зэрэг талаар илэрдэг. Шилдэг утга зохиолын түүхийн заах материал нь туурвигчийн хувь хүний үзэлт хийгээд хувь хүний илрүүлэл нь заавал эрдэм шинжилгээнийхэнд мэдрэгдсэн суурин дээр бичиж оруулсан байх хэрэгтэй. Монгол утга зохиолын түүх судалгаанд бид өмнөх судалгааны үр бүтээмжийг шинжлэх ухаанчаар дүгнэж, хойшдын судалгаанд бүтээлчээр ашиглаж, монгол утга зохиолын түүх судалгааны шинэ цар хүрээг нээж, тус судалгааг шинэ нэгэн өндөрцөд хүргэх чухалтай юм.

⁷ 论新文学史思维模式的革新与重构冯光廉林凡《文学评论》1993·6, 51页



THE CULTURAL WAY

ABSTRACT

The historical mission of literature is, on the one hand, the changing process of interpretation, criticism, and appreciation by readers and critics, and, on the other hand, the process of cooperative development of co-authors with their genres, linguistic traditions, and other works, and the process of development of works that explore the internal structure of literature. This thesis mainly studies the history of Mongolian literature in the Mongolian language from three aspects: the study of specific textbooks and textbooks, the study of historical writing methods, and the study of historical bureau and its cultural roots.

Key words: *Mongolian study on the history of Mongolia literature, historical records, method principle*

НОМ ЗҮЙ

1. 唯物史观与文学史编写林继中《江海学》1994年
2. 文学史观的反思与重构许总《文学评论》1995年
3. (美) 勒内韦勒克奥斯汀沃伦《文学理论》江苏教育出版社2005年
4. 略论文学史研究中的文化意识汤漳平《社会科学辑刊》1995年
5. 论新文学史思维模式的革新与重构冯光廉林凡《文学评论》1993年

ХАЙР ДУРЛАЛЫН МӨНХИЙН ДУУЛАЛ

Улаан асарын зүүд болон Нэгэн давхар асарын харьцууллын жишээн дээр

Ван Ин*

ХУРААНГУЙ

Тус өгүүлэлд голдуу харьцуулсан утга зохиолын зэрэгцээ харьцууллын аргыг хэрэглэн, дундад улсын эртний сонгодог зохиолч Цао Шюэчинь-ий Улаан асарын зүүд болон монгол үндэстний ойр үеийн алдарт зохиолч Инжинаашийн Нэгэн давхар асарыг дүр төрөхийн бүтээлт, үлгэр үйл явдлын тохируулалтын толидол хийгээд өвөрмөц шинж, урлагийн хэв маяг зэрэг талаас харьцуулж, тэдгээрийн нийтлэг өвөрмөц чанарыг шинжлэн судлахаар дамжин Инжинаашийн Нэгэн давхар асар нь Улаан асарын зүүдийг толилон суралцсан боловч түүний хуулбар биш, харин үндэстний онцлогийг уялдуулан оруулсан зэрэг өвөрмөц онцлог агуулагдаж байгаа бүтээл болно.

Түлхүүр үгс: *Цао Шюэчинь, Инжинааш, Улаан асарын зүүд, Нэгэн давхар асар*

Улаан асарын зүүд бол чин улсын үеийн зохиолч Цао Шюэчинь-ий зохион бүтээсэн бүлэгт роман юм. Мөн дундад улсын эртний дөрвөн их сонгодог бүтээлийн нэг болно. Түүнээс сүүлээр 后红楼梦, 续梦, 圆梦, 红梦 зэрэг гарчиггаар зохиогдсон Улаан асарын зүүдний үргэлжилсэн номууд их хэмжээгээр илрэн гарч ирсэн мөртөө 花月痕, 品花宝鉴, 青楼梦 жич ойр үеийн монгол үндэстний утга зохиолч – Инжинаашийн монгол хэлээр зохион бүтээсэн Нэгэн давхар асар болон Улаанаа уйлах тэнхим нь бүр Улаан асарын зүүднээс сэдэлт олж, түүнийг дууриан бичсэн гэж үзэж болно. Гэвч Инжинаашийн зохион бүтээлт нь Улаан

* Өвөр Монголын Их Сургууль, Монгол Судлалын Дээд Сургуулийн магистрант



асарын зүүдний хуулбар биш, харин өвөрмөц онцлог агуулагдаж байгаа шинэ бүтээл юм.

Нэгэн давхар асар бол зохиолч Инжинаашийн зохиосон монгол үндэстний уран зохиол, ардын аман яриа, домог үлгэр болон түүхийн үлгэрийн сэдвээс ангижран, тухайн нийгмийн бодит амьдралд үндэслэн зохиогдсон анхдагч роман болно. Ийд харьцуулсан утга зохиол бол олон улсын хараа болон харьцуулсан аргаар явагдсан утга зохиолын түгээмэл жам ёс болон онцлогийг хайн сүвэгчилж байгаад утга зохиолын солилцоо ба хөгжлийг ахиулдаг үндэстэн алсалсан, соёл алсалсан, шинжилгээний салаа алсалсан утга зохиолын судалгаа юм¹. Доор голдуу Улаан асарын зүүд болон Нэгэн давхар асарыг харьцуулан өгүүлнэ.

Нэг. Дүр төрөхийн бүтээлт

Улаан асарын зүүдэнд бүтээсэн дүр зуу гаруй байдаг. Үүнд Улаан асарын зүүдийг толь болгосон Нэгэн давхар асарт бүтээсэн дүр цөөн, уншигчдад гүн санаа үлдээж чадсан дүр нь хамгийн олондоо дөчин хүнээс хэтрэхгүй юм. Инжинааш толь болгохдоо олон дүрийг хасаж хаяснаар барахгүй бас зарим дүрүүдийн зан чанарыг нь нийлүүлж, зарим дүрийг нь арчиж хаясан байна.

Инжинаашийн Нэгэн давхар асарт үлдээж хоцроосон дүрүүдийг сайтар задлан шинжлэх юм бол зан чанарын зөрөөг нь амархан олж мэдэж чадах юм. Тухайлбал, Лү Мэй, Линь Дайюй-тай төстэй, гэвч тэдний зан чанарт зөрөө оршдог. Линь Дайюй өвчин эмгэгт нэрвэгдсэнээр барахгүй сэжиг дагавар ихтэй, үйл ажиллагаа нь зөрчилтэй, үг яриа нь хурц ширүүн, бусдыг амархан гомдоон шархлуулдаг. Харин Лү Мэй бие бялдар чийрэг, эвсэг, оморхог боловч сэжгээр дутмаг, үг яриа нь хурц ширүүн боловч хүнийг гомдоон шархлуулдаггүй. Линь Дайюй Жянь Баоюй-д хайртай боловч сэтгэлээ нууж байдаг, гэтэл Лү Мэй Фу Юй-д хайртай болсноо идэвхтэй, зоригтойгоор илтгэн гаргадаг. Үүнтэй харьцуулбал, Линь Дайюй цэвэр нарийн хайр сэтгэл, яс сийлэм гуниглал гутралаар хүмүүсийг нулимс бөмбөрүүлж, Лү Мэй харин борогжуу хайр сэтгэлээрээ хүмүүсийг гайхашруулна.

¹ 孟昭毅、黎跃进、郝岚编著：《简明比较文学原理》，《北京大学出版社》，2010年，第15页



THE CULTURAL WAY

Чинь Мо, Шюэ Баочай-тай төсөтэй, гэвч тэр хоёрын үзэл санааны тал нэлээд зөрөөтэй байдаг. Шюэ Баочай Улаан асарын зүүдэнд амархан маргаан үүсгэх дүр юм. Юу ч болсон ч тэр эелдэг даругийн цаана зүсэр зальхай тал нуугдаж, номхон зан аалийн цаана ондоо арга ухаан, ов мэх гаргана. Өгөөмрийн цаана хувиа хичээмтгий зан агуулдаг бөгөөд хайр дурлалын талаар феодалын гэрийн ахмадын үзэл суртлыг дагаж, өөрийн ураг хуримаа гэрийн ахмад нарын өдөөлгө дэмжлэгээр бүтээх хэмээн явц болгон дээр гэрийн ахмадын санаанд нийцүүлэн, тэдэнд тоогдож явахаар хичээдэг. Харин Чинь Мо тийм биш, тэр гэнэн цагаан, эелдэг дотно, багтаамжтай, далд цаана нь илүү арга самбаа байдаггүй бөгөөд Лү Мэй хайр дурлалын талаар гэрийн ахмадад түшиглэх хэмээн хичээх боловч Фу Юй-д өөрийн хайраа зоригтой илтгэнэ. Мөн Шөнрү биеийн гарал өнгөрөлт дээр Ши Шяньюнь-тай төстэй боловч тэрээр ер нь үг дуу цөөн, цайлган, дорой буурай, Ши Шяньюнь шиг аймшиггүй ярьж үйлддэг хүн биш юм.

Фу Юй болон Жянь Баоюй-г ажиглан үзвэл, энэ хоёр дүр адил талтай боловч ерөнхийд нь авч хэлбэл мөн л ялгаа зөрөө оршиж байдаг. Жянь Баоюй багаасаа феодалын хүмүүжлийг эсэргүүцдэг мөртөө энэхүү үзэл нь өсөн торних тутам буурсангүй, ноён суухад ер нь таагүй байдаг. Харин Фу Юй багадаа дургүйцэж байсан ч ургаж гүйцсэний сүүлээр аажмаар ноён суух замыг хөөж, сэтгэл ханз сэнгэлзэн баярладаг байжээ. Ийм ялгааг зөрөөг тэдний феодалын гэр бүлдээ хандах овор суртлын талаас үзвэл нэн тодорхой байж мэднэ. Жянь Баоюй түүний эцэг Жянь Жөн-тэй үргэлжилсэн маягийн эсэргүүцэлдэл явагдаж байв. Эсрэгээр Фу Юй эцэг Бэй Си-тэй хэдий зөрчилтэй боловч нэгдэхэд бэрх биш билээ. Товчлоод хэлбэл, хэрэв Жянь Баоюй бол феодалын эш ёсны урван тэрслэгчид хүрвэл, Фу Юй зөвхөн үл хамтран ажиглагч төдий юм. Дахиад Жянь Баоюй болон Фу Юй-ийн үзэл санааны ялгаа зөрөө нь ураг хуримыг хөөцөлдөх байдалд ч илэрнэ. Жянь Баоюй Линь Дайюй-д хайртай гэсэн явдалд эрс шуурхай байдлаар ханддаг. Линь Дайюй-г хөгшрүүлэхгүйн төлөө Жянь Баоюй гэрийн хүмүүстэйгээ эсэргүүцэн тэмцэлдэж, цаашлаад гэрээсээ салан, сүмд орж лам суухаар болсон юм. Түүнтэй харьцуулбал, Фу Юй феодалын ёс суртахууны хорио цээрийг давж чадахгүй, арга бус феодалын гэр бүлийнхэн түүнийг зөвшөөрөх эсэхэд хүсэл өвөрлөдөг. Товчлон хэлбэл хэрэв Жянь Баоюй-г чөлөөт ургийн тэмцэгч гэвэл Фу Юй зөвхөн түүнийг хүсэн мөрөөдөгч төдий юм.



Хоёр. Үлгэр үйл явдлын тохируулалтын толидол хийгээд өвөрмөц шинж

Нэгэн давхар асар нь үлгэр үйл явдлын талаар Улаан асарын зүүд зэрэг хятадын эртний сонгодог романы бүтээлүүдийн нөлөөг гүн хүртжээ. Инжинааш үүний тухай нуун далдалсангүй мөртөө Нэгэн давхар асарын оршлын хэсэгт: “Эрт Цао Шюэчинь-ий найруулсан хуучин Улаан асарын зүүдийг үзвээс уярах, баярлах, хагацах, хамтатгах нь гурван төрлийн чухлыг нийлүүлэн хувилгаан шидтэний өргөхийг сэнгэрүүлж инээх, наадах, хилэгнэх, хараах нь, зуун мянган биеийг илрүүлж, бодисадва, махасадва нарын номыг өгүүлжүхүй”² гээд тийнхүү би бээр тэдгээрийн цэлгэр сүнснийг цуглуулж, миний мунхаг сэтгэлийг дэлгэрүүлээд ...”³ гэжээ. Инжинааш санаачилгатайгаар Улаан асарын зүүднээс суралцан Нэгэн давхар асарын оршлын хэсэгтээ бодитой зөвхөн бүтээлтэд бүхий л цогцын бүтцээс дүр төрөхийн бүтээлт, нарийн зүйлсийн сонголтоос илтгэх арга хүртэл олон талаас Улаан асарын зүүднээс толидож суралцсанаа тодорхой өгүүлжээ. Жишээ нь: Улаан асарын зүүд дэх Лю эмгэн гурвантаа Жянь ордонд орсон ба Нэгэн давхар асар дахь Бэй Лаогуа-ийн гурван удаа Бэй Хөү Жинь яаманд орсон зэрэг үйл явдалтай адилавар байдаг.

Инжинааш Улаан асарын зүүднээс суралцаж толь болгохоор дамжин монгол хятад үндэстний хоёр зүйлийн соёлыг цогцлоосон байна. Нэгэн давхар асар нь даруй иймэрхүү уусалцлын бүтээгдэхүүн юм. Дурдууштай нь тус бүтээл чин улсын сүүлч үеийн говийн өмнөх монгол гэх онцгой хараагаас гар дүрэн, нийгмийн амьдрал, зан заншил жич хүнийг дүрслэн бичихдээ бүр монгол үндэстний онцлогтой юм. Иймэрхүү зохион бүтээлт нь эртний роман дахь анхны үүдэлт болжээ. Энэхүү онцлог нь бүтээсэн дүрийн өдөр тутмын амьдралд монгол үндэстний амьдралын онцлогийг хандуулж байхад илэрнэ. Тухайлбал, Фу Юй эцгээ төлөөлж гадагш түрээслэх мөнгө авахад, түүний төрсөн эх Вү Инян нь нэлээд олон замдаа идэх цагаан идээг өгч, Сү Жиедү Бэй Ситэй Фу Юй болон Сү Жи-ийн ургийг хэлэлцэн тогтсоны дараа Сү Жиедү

² Инжинаашийн бүрэн зохиол, Нэгэн давхар асар. ЛяҮнХХ., 2018 т 1

³ Инжинаашийн бүрэн зохиол, Нэгэн давхар асар. ЛяҮнХХ., 2018 т 1



их л баярлаж биед зүүсэн орос улсын хэт оронгын эврийн хутгыг авч⁴ Фу Юй-д шагнан өгч, Сү Жиедү хүүхэн өгөх ёсны бэлэгт мөнгөн буйлт цагаан тэмээ тэргүүлэн тэмээ арван ес, эмээл хазаарт морь тэргүүлэн хорин ес, хонь тэргүүлэн шүүс гучин ес⁵ зэрэг, Фу Юй Сү Жиедү, Фүжинь хоёрт урт цагаан хадаг барин ёслон мөргөжээ, Сү Жиедү, Фүжинь хоёр болор аяганд сүү хийж хүргэн хүүхэн хоёрт амсуулсан⁶, урьд гэрт орсны сүүлээр, Фу Юй бие эргэж зүүн этгээдийг эзлэн суусан хойно буриад найз Сү Шяожие-г эргүүлэн баруун этгээдэд зүүн зүг хандуулан суулгав⁷ зэрэг болно. Эдгээр монгол үндэстэнд л байдаг зан дадал юм. Зохиолч иймэрхүү нарийн зүйлсийн дүрслэлээр дамжуулан уншигчдад түүний бичсэн нь монгол үндэстний амьдрал мөн гэдгийг мэдүүлсэн байна.

Гурав. Урлагийн хэв намба */хэв маяг/*

Урлагийн хэв маягийн талаар хэлбэр ба ур мэргэжлийн хэрэглэлт, өнгө будгийн дүрслэн хэрэглэлт, хайр сэтгэлийн илтгэлт гэх хэдэн талаар харьцуулж болно.

(Нэг) Хэлбэр ба ур мэргэжлийн хэрэглэлт

Нэгэн давхар асар болон Улаан асарын зүүд нь хэлбэр болон ур мэргэжлийн талаар илэрхий ялгаа зөрөө оршдог. Энэ нь голдуу доорх хэдэн талаар илэрч байдаг.

1. Хэлний хэрэглэлт

Улаан асарын зүүдний үг хэл нь яруу сайхан, их хэмжээний уран найруулгын аргуудыг хэрэглэсэн байна. Жишээ нь 月满则亏, 水满则溢, 金玉良缘 зэрэг нь зохиол бүтээлийн үг хэлийг нэн үзэсгэлэн сайхан болгосон байна. Үүнтэй харьцуулбал, Нэгэн давхар асарын үг хэлний хэрэглэлт нь харьцангуй энгийн, амьдралд ойртсон нь монгол үндэстний ярианы онцлогийг илрүүлжээ. Жишээ нь баяр дурсгалын өдөр, гэр бүлийн цуглаан, найрал дуу зэрэг өдөр тутмын амьдралын олон талбар,

⁴ Инжинаашийн бүрэн зохиол, Нэгэн давхар асар. ЛяҮнХХ., 2018 т 479

⁵ Инжинаашийн бүрэн зохиол, Нэгэн давхар асар. ЛяҮнХХ., 2018 т 490

⁶ Инжинаашийн бүрэн зохиол, Нэгэн давхар асар. ЛяҮнХХ., 2018 т 497

⁷ Инжинаашийн бүрэн зохиол, Нэгэн давхар асар. ЛяҮнХХ., 2018 т 498



үзэмж байдлыг зураглан бичихдээ гоц сайхан үг өгүүлбэрийг хэрэглэсэнгүй ч хүмүүсийн сэтгэлд хоногшсон, уншигчдын сонирхлыг татдаг.

2. Хүүрнэлийн бүтэц

Улаан асарын зүүд нь будлиантай хүүрнэлийн бүтцийг хэрэглэж, олон сүвэгч ба зогсоцоос үлгэрээ дэлгэн, өргөн хэмжээний мөртөө будлиантай хүний харьцааны дүрийг дэлгэн үзүүлсэн байна. Жишээ нь зохиогч олон дүрүүдийн хувь тавилан ба хайр сэтгэлийн солбицуулаар дамжуулан феодалын нийгмийн зүйл зүйлийн хор гэм болон хүн чанарын будлиантай байдлыг илрүүлсэн байна. Нэгэн давхар асар нь дөхөм хэлбэрээр үлгэрээ тоочиж, үлгэрийн сэжим нь харьцангуй тодорхой байдаг. Жишээ нь зохиолын гол дүр Фу Юй-ийн гурван эмэгтэйчүүдийн хооронд хайр сэтгэлийг шууд бөгөөд тодорхой илрүүлж, уншигчдад үлгэрийн гол үйл явдлыг үтэр түргэн мэдүүлдэг.

3. Соёлын агуулахуун

Улаан асарын зүүд нь хятад үндэстний уран зохиолын төлөөлөгч бүтээл болсны хувьд элбэг баялаг соёлын агуулахуун болон түүхийн ахуй байдалтай уусаж, феодалын нийгмийн зүйл зүйлийн гэм архаг болон хүн чанарын будлиант шинжийг илрүүлсэн байна. Жишээ нь хувцас засал, идээ ундаа, барилга, шүлэг дуулал, шашин суртахуун зэрэг олон талаар тухайн нийгмийн соёлын дүрс байдал ба гоо сайхны хөөцөлдлийг илрүүлж, хожмын үеийн уран зохиолын зохион бүтээлт ба соёлын судалгаанд алс хэтийн нөлөө үзүүлжээ. Нэгэн давхар асар нь монгол үндэстний соёл ба амьдралыг зураглахыг нэн чухалчилж, монгол үндэстний ард түмний амьдралын байдал болон урам сэтгэлийг илрүүлсэн байна. Жишээ нь зохиол дахь оньсого таах, дуу дуулах, бүжиг бүжиглэх гэх мэтийн монгол зан заншлыг дүрсэлсэн нь монгол үндэстний ард түмний амьдралын зан заншил ба соёлын уламжлалыг амьд байдлаар илрүүлсэн байна.

Ерөнхийлөн хэлбэл Нэгэн давхар асар нь хялбар ойлгомжтой хүүрнэн тоочих арга болон шууд илтгэх аргаар бодит урлагийн хэв маягийг илэрхийлсэн байна. Улаан асарын зүүд нь нэн будлиантай, нарийн зохион бичих арга дүйг хэрэглэсэн байна. Тухайлбал олог талаас хүүрнэн тоочих,



сэжим сүвэгч бичих зэрэг нь уран бүтээлд гүн зузаан урлагийн арга дүйг олгон өгчээ.

(Хоёр) Өнгө будгийн дүрслэн хэрэглэлт

Улаан асарын зүүд болон Нэгэн давхар асарын өнгө будгийн дүрслэн хэрэглэлтийн талаар зохих зөрөө оршдог, энэ нь хоёр зүйлийн адил бус соёлын ахуй байдал ба хэв маягийн онцлогийг тусгажээ. Доорх бол хоёр зүйл дэх өнгө будгийн хэрэглэлтийн тухай задлалт бөгөөд бодит жишээгээр дамжуулан тодорхойлолт хийв.

1. Өнгө будгийн баялаг шинж болон бэлгэдлийн шинж

Улаан асарын зүүд дэх өнгө будгийн хэрэглэлт нь нэн элбэг баялаг бөгөөд гүн гүнзгий бэлгэдлийн ач холбогдолтой юм. Жишээ нь улаан өнгө нь-үргэлж хайр халамж, уйтгар гуниг зэрэг хайр сэтгэлтэй нягт холбоотой байдаг. Жянь Баоюй-ийн бие дээрх улаан хувцас нь түүний хайр сэтгэл болон гунигт учралыг бэлгэддэг.

2. Өнгө будгийн бодит чанар болон аясын шинж

Нэгэн давхар асар дахь өнгө будгийн тухай дүрслэн хэрэглэлт нь аясын шинжтэй, монгол тал нутгийн үнэн бодит өнгө дүрсийг дахин илрүүлэхийг чухалчлав. Жишээ нь зохиолд монгол тал нутгийн ногоон өнгө, хөх огторгуй, цэцэг хуарын ялгарам өнгө будаг /дүрслэл/ зэргийн нарийн гүн зураглал нь байгалийн гоо сайхныг харуулж байна.

3. Өнгө будгийн хайр сэтгэлийн илтгэлт

Улаан асарын зүүд дэх өнгө будгийн хэрэглэлт нь үргэлж хүмүүсийн хайр сэтгэлтэй нягт холбоотой байдаг. Жишээ нь Линь Дайюй ногоон өнгөтэй хувцас өмсөж байгаа нь түүний зөөлөн бөгөөд сэжиг ихтэй зан чанарыг харуулж байна. Ван Си Фен харин улаан өнгийг өмсөж байгаа нь түүний цэгц шулуун, омог зоригтой зан аашийнх нь онцлогийг илрүүлдэг.

4. Өнгө будгийн нийгэм соёлын агуулахуун

Улаан асарын зүүд дэх өнгө будгийн хэрэглэлт нь бас тухайн үеийн нийгэм соёлын агуулахууныг тусгасан байна. Жишээ нь шар өнгө



нь феодалын нийгэмд хааны эрх ба эрхэм хүндийг бэлгэдэж, ногоон өнгө нь хэзээд залуу нас, амьдралын хүчтэй холбоотой байдаг. Ерөнхийлөн хэлбэл, зохиол бүтээл дэх өнгө будгийн дүрслэн хэрэглэлтийн талаар Нэгэн давхар асар нь дан цулгүй, байгалийн өнгө ба өдөр тутмын өнгийг чухалчлан дүрслэн хэрэглэснээс нэг зүйлийн энгийн хэв маяг илэрч байдаг. Улаан асарын зүүд дэх өнгө будгийн дүрслэн хэрэглэлтээр нэн баялаг, онцгойлон ахуй талбар болон хүний хувцас заслыг дүрслэхэд өтгөн зузаан, тансаг сайхан өнгө будгийг дүрслэн хэрэглэж, нэг зүйлийн баялаг утга агуулгатай урлагийн үр дүнд хүрсэн байна.

(Гурав) Хайр сэтгэлийн илтгэлт /илрэл/

Хайр сэтгэлээ илтгэх талаар Нэгэн давхар асарт ер нь үнэнч энгийн хайр сэтгэлийг илүү илрүүлж, эгэл хүмүүсийн амьдралыг зураглахаар дамжин уншигчдад илтгэх гэж байгаа сэтгэлийг уран сайхан мэдүүлдэг. Улаан асарын зүүд нь нарийн сайхан сэтгэлийн хөдөлгөөний дүрслэл болон хайр сэтгэлийн зууралдаанаар дамжин уншигчдад хүн чанарын будлиант чанар хийгээд хайр сэтгэлийн гүн гүнзгийг мэдрүүлдэг.

1. Хайр сэтгэл гүн зузаан

Улаан асарын зүүдний хайр сэтгэл нь нэн гүн гүнзгий бөгөөд будлиантай. Зохиолд олон янз хүний амьдрал, гунигт хувь заяа, хайр сэтгэлийн гүн зузааныг зураглан бичжээ. Жишээ нь Жянь Баоюй болон Линь Дайюй-ийн хоорондын хайр сэтгэлийн зууралдаан нь гүн гүнзгий мөртөө гунигтай, хүний амьдралын хэв бус болон хувь заяаны арга бус талыг илрүүлжээ.

2. Хайр сэтгэлийн аяндааны /аясын/ илрэл

Нэгэн давхар асарын хайр сэтгэлийн илрэл нь нэн шулуун, дараас ба халхавч цөөн байдаг. Жишээ нь монгол үндэстний ард түмний тал нутагт чөлөөтэй чөлөөтэй явж байх ба тэд нарын баяр хорсол гомдол гуниг нь бүр үг яриа үйл ажиллагаа нь шууд илэрч, дотоод сэтгэлийн зөрчил ба тэмцэл гэж тийм зүйл байхгүйгээс илрэлтэй.



3. Гунигт жүжгийн урам сэтгэлийн өнгө будаг

Улаан асарын зүүд дэх сэтгэлийн гунигт жүжгийн өнгө будаг нь нэлээд гүн зузаан байж, зохиол нь феодлын нийгмийн зүйл зүйлийн гэм буруу ба хүн чанарын будлиант шинжийг илрүүлж, маш олон үйл явдлыг цөм гунигт жүжгийн өнгө будагтай болгожээ. Жишээ нь Жянь Баоюй болон Линь Дайюй-ийн янаг дурлал */хайр дурлал/-*ын гунигт жүжиг нь феодлын ёс суртахууны хүн чанарын хүлээслэл ба нийгэмд хайр найргүй байхыг тусгасан байна.

4. Хайр сэтгэлийн хүсэнгүйч */хүсэгч, мөрөөдөгч/* чанар

Нэгэн давхар асарын хайр сэтгэлийн илрэл нь хүсэнгүйч үзлийн тийш хэлбийж, зохиолд монголын тал нутгийн зураглал ба монгол үндэстний ард түмний хайр сэтгэлийн илрэл нь бүр хүсэнгүйч үзлийн өнгө будагтай юм. Жишээ нь Фу Юй-ийн дүр нь хүслэнчилсэн онцлогтой байж, түүний эрэлхэг зориг ба оюун ухаан нь хүсэнгүйч үзлийн бэлгэ тэмдэг болсон байна. Дээрх хэдэн талын ялгаа зөрөөнөөс хоёр зохиолчийн адил бус зохион туурвих ойлгохуй болон хэв маягийг харуулж чадсанаар үл баран бас тэдний нийгэм болон хүн чанарын тухай өвөрмөц ойлголт хийгээд шинжин ажиглах чадварыг ч харуулж чадсан байна.



ДҮГНЭЛТ

Эн тэргүүнд, Улаан асарын зүүд болон Нэгэн давхар асар нь соёлын ахуй байдал зэрэг талаар жаахан зөрөөтэй боловч утга зохиолын үнэ өртөг /үнэ цэн/ ба урлагийн амжилтын талаар цөм оргилдоо хүрчээ. Хоёр бүтээл нь хүмүүсийн зан чанарыг нарийн дүрслэн, үйл явдлын тохируулалт болон нийгмийн ар үзэгдэлд гүнзгий шинжлэл хийхээр дамжуулж өөр өөрийн өвөрмөц онцлогоо харуулсан байна. Хоёрдугаарт, гол сэдвийн илтгэлтдээ Улаан асарын зүүд нь гэр бүлийн мандал доройтол, хүн чанарын сайн муу зэрэг аугаа их гол сэдвийг нэн анхаарч, Нэгэн давхар асар нь харин хувь заяа ба хайр сэтгэлийн тухай нэн илүү анхаардаг. Гэтэл хоёр зохиол бүтээл нь амьдрахуйн гүн ухааныг сүвэгчлэх, нийгмийн бодит ахуйг илрүүлэх зэрэг талаар хүмүүсийг цочоом адилагтар байгаа нь утга зохиолын бүтээлийн түгээмэл үнэн ёсыг уламжлах талаарх өвөрмөц үнэ цэнийг улам нэг алхам гэрчилсэн байна. Гуравдугаарт, хоёр бүтээлийг харьцуулахаар дамжуулж бид тэдгээрийн утга зохиолын зохиол бүтээл дэх адил бус тал ба сайн мууг олж мэджээ. Эдгээр зөрөө нь дүр төрөхийн бүтээлт, урлагийн хэв маяг зэрэг талаар илэрч байхаар үл баран, нэн ч хүн чанар, хайр сэтгэл зэрэг гүн давхаргын асуудлыг ойлгох ба илтгэх дээр илэрч байдаг. Эдгээр адил бус тал нь манай утга зохиолын харааг баялагжуулснаар барахгүй бидэнд нэн гүнзгий сэтгэх ба толь болгох орон зайг ханган өгчээ.

ABSTRACT

This article mainly adopts the parallel research method of comparative literature to compare Cao Xueqin's "Dream of the Red Mansions" and Yin Zhannaxi's "One Storeyed Pagoda" from the aspects of image creation, reference of story plot configuration, characteristics, artistic style, etc. Through the exploration of their commonalities and personalities, although Yin Zhannaxi's "One Storeyed Pagoda" draws on "Dream of the Red Mansions", it is not a replica, but a new work that incorporates ethnic characteristics.

Key words: *Cao Xueqin, Yin Zhannaxi, "A Dream of Red Mansions", "One Storeyed Pagoda"*



П.ХОРЛООГИЙН СУРГАН ХҮМҮҮЖЛИЙН ҮЗЭЛ САНАА
БҮХИЙ ТАЙЗ, ДЭЛГЭЦИЙН БҮТЭЭЛ

Б.Туяа*

ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд П.Хорлоогийн зохиол бүтээл, судалгаа шинжилгээний бүтээл түүний дотроос Монголын хүүхдийн уран зохиолд оруулсан хувь нэмэр, үзэл баримтлал зэргийг тодруулжээ. Үүнд их эрдэмтний сурган хүмүүжлийн үзэл санаа, энэхүү үзэл санаа нь тайз, дэлгэцийн бүтээлд хэрхэн шингэснийг эргэн харж, тэдгээр бүтээлийн онцлог, шинэлэг тал, ач холбогдлыг нэгтгэн дүгнэхийг зорив.

Түлхүүр үгс: *П.Хорлоо судлал, сурган хүмүүжлийн үзэл санаа, тайзны бүтээл, дэлгэцийн бүтээл*

Хүн төрөлхтөн үүсэн бий болохтой зэрэгцэн үр хүүхэд, хойч үеэ сурган хүмүүжүүлэх шаардлага бий болсон учир сурган хүмүүжүүлэх зүйг хамгийн эртний ухаан гэж хэлж болно. Түүнчлэн эртний түүх, соёлтой аль ч улс, үндэстэн үеэс үед уламжлан, улам бүр төгөлдөржиж, боловсрон хөгжиж ирсэн сурган хүмүүжүүлэхүйн арвин өв уламжлалтай байдаг. Хэдий тийм ч тухайн ард түмний оршин байгаа газар зүй, цаг уурын нөхцөл, эрхэлдэг аж ахуй, ажил хөдөлмөр болоод эдгээрээс урган бий болсон соёл иргэншил, үзэл сэтгэлгээний өвөрмөц онцлог зэрэг олон зүйлээс шалтгаалан хүүхдийг хэрхэн ямар аргаар,

* Өвөр Монголын Их Сургуулийн докторант



юунд голлон сургах вэ, ямар хүмүүжил мэдлэгийг эзэмшсэн хүн болж төлөвшвөл зохих вэ гэдэг нь өөр юм. Иймээс сурган хүмүүжүүлэх ухаанд дэлхий нийтээр баримтлан мөрддөг тогтсон онолын ойлголтууд байх хэдий ч дээр өгүүлсэн онцлогуудаас хамааран улс үндэстнүүд тус тусын уламжлалт арга зүйг өвлөн уламжилдаг билээ.

Аливаа улс үндэстний урлаг, утга зохиолын бүтээл туурвилын дотор аль ч цаг үед чухлаар тавигдаж, зохиолч, уран бүтээлчдээс нөр их хөдөлмөр, судалгаа шинжилгээ, олон талын мэдлэг, мэдрэмжийг шаарддаг онцгой нэгэн төрөл нь хүүхдэд зориулсан урлаг, утга зохиол, тайз, дэлгэцийн бүтээлүүд юм. Дэлхийн олон улс үндэстний нэгэн адил монголчууд ч эрт цагаас хүүхэд багачуудын ой ухаан, авхаалж самбааг тэлэх, эрүүл зөв амьдрах арга ухаанд сургах, байгаль орчин эх дэлхийгээ хайрлан хамгаалах, хэл, хэлэхүйн чадвар, сэтгэхүйн хурд зэргийг хөгжүүлэх аман зохиол, тоглоом наадгайн арвин баялаг уламжлалтай билээ. Тухайлбал, монгол аман зохиолын ерөөл, магтаал, оньсого, таавар, зүйр цэцэн үг, дайралцаан, хэл зүгшрүүлэх үг гээд бүхий л төрөл зүйлс хүүхэд багачууд, хойч үедээ үлдээсэн үнэт өв юм. *“Энэ арвин баялаг далайгаас хүүхдүүд хэлд ормогц л хүртэж эхэлдэг. Үлгэр хэлэлцэж, оньсого таалцаж, үгэн тоглоомоор тоглодоггүй монгол хүүхэд ховор”*¹ билээ.

Өнөө цагт техник технологийн хурдацтай хөгжил, орчин үеийн нийгмийн өөрчлөлт, хөгжил дэвшлийн зарим онцлогоос шалтгаалан хүүхдийн тоглоом наадгай, сурч боловсрох зүйлс нь

¹ Батжаргал Д. 2011. *Хүүхдийн яруу найргийн уран чадварын зарим асуудал*. Уб.,



өөрчлөгдөж, ухаалаг гар утас, зурагт, компьютерын хэрэглээ ихсэж, нийгмийн сүлжээ ашиглах, цахим тоглоом, наадгай голлон тоглох болжээ. Хэдий тийм ч хүүхдийн уран зохиолын үүрэг нөлөө аль ч цаг үед тэдний хүмүүжил боловсролд чухал нөлөөтэй байдаг билээ. Зөвхөн хүмүүжил боловсрол ч бус тэдний танин мэдэхүй, урлаг, уран зохиолд дурлах, тэдгээрийг ойлгож мэдрэх, гоо зүй, ёс суртахууны мэдрэмжтэй болоход хамгийн ойр дөт төрөл зүйл нь хүүхдийн шүлэг юм.

*“Хүүхдэд зориулсан яруу найраг уран зохиолын бусад төрөл зүйлийн дотор хамгийн хариуцлагатай ур чадвар шаардсан, донж маягийг олоход төвөгтэй, хэл найруулга, хэмжээ, хэмнэл нь нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн байх өвөрмөц, нарийн чимхлүүр урлаг”*² билээ. Тиймээс хүүхдийн уран зохиол түүний дотроос хүүхдэд зориулсан яруу найргийн бүтээлүүдийг онцгойлон судалж сэдэв, өгүүлэмж, хэл найруулга, уран бүтээлчдийн онцлог зэргийг үнэлэн цэгнэх нь уран зохиол судлалын нэгэн чухал судлагдахуун юм. Тиймээс бид энэхүү өгүүлэлд академич П.Хорлоогийн сурган хүмүүжлийн үзэл санаа бүхий тайз, дэлгэцийн бүтээлийг онцлон авч судлахыг зорилоо.

I. Сурган хүмүүжлийн үзэл санаа ба зохиолч П.Хорлоо

Пүрэвийн Хорлоо бол 1930-аад оны дунд үеэс шүлэг зохиол бичиж эхэлсэн 1940, 1950-аад оны үеийн яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиолын голлох төлөөлөгчдийн нэг төдийгүй насан эцэслэх хүртлээ зохиол бүтээлээ туурвисаар явсан МЗЭ-ийн 015 тоот батлахын эзэн манай ахмад эрдэмтэн зохиолч билээ. Тэр

² Батжаргал Д. 2011. *Хүүхдийн яруу найргийн уран чадварын зарим асуудал*. Уб.,



бээр шинэ үеийн Монголын уран зохиолыг үндэслэгчид болох Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ц.Дамдинсүрэн, М.Ядамсүрэн, Ши.Аюуш нарын халааг залгамжлан гарч ирэгсдийн нэгэн бөгөөд тэдний заримын бараа сүүдрийг харж, шүлэг зохиолыг нь сонсож заримтай нь нүүр тулан уулзаж, захидал бичгээр харилцаж, Ц.Дамдинсүрэнтэй олон жил хамтран ажиллаж байсан хүн юм. Жишээ болгож нэгэн захидлыг дор сийрүүлбээс:

“... Ховд аймгийн Манхан сумын ардын бага сургуулийн багш Хорлоогоос хичээнгүйлэн:

Эрхэм журмын итгэлт нөхөр Буяннэмэх, Аюуш нарын амрыг эрж ёслохын гадна, эрхмүүдийн амар сайныг айлтган бариулав. Энэ үед миний бие мэнд сайн бөгөөд өөрийн удирдагч Улс төрийн уран сайхны зөвлөлөөс даалгасан ажлыг өөрийн сургуулийн дотор 13 хүүхэд бүхий уран зохиолын бүлгэм байгуулан ажилласаар хоёр сар шахам болж буй бөгөөд сурагчдад өөрийн чадах мэдэхийн чинээгээр зааж сурган буй. Одоогоор бичсэн зохиолыг явуулъя гэсэн боловч завдсангүй тул дараагаар сургууль тармагц хот орохоор тусгай дэвтэр болгон авч орохыг та бүхний сонорт мэдүүлье.

Эрхэм хүндэт уран зохиолчид ба Улс төрийн уран сайхны газраа хувийн зүгээс хүсээж мэдүүлэн гуйх нэгэн зүйл нь:

Өчүүхэн би алс хол газарт сууж байхын завсарт зохион бичсэн 40 гаруй шүлэг, найруулгын зүйлийг бичсэн бөгөөд тэрхүү зохиолууд нь өчүүхэн хүний хувийн мэдрэлийн чинээ байдлаар зохиогдсон болох тул арга буюу түүнийг тусгай дэвтэр болгон гаргаж шалгуулахыг хүсээж буй тул түүнийг хэвлэж болох, эсэхийн тодорхой хариуг янагш явуулахыг хүндэт алдарт гавьяат



уран зохиолч Буяннэмэх, Аюуш нараас хичээнгүйлэн гуйсугай Мөн улс төрийн уран сайхнаас шинээр явуулан буй сонин сайхан ажил хэргүүдийг өчүүхэний зүг зурвасаар шагнан хайрлахыг түмэнтээ хүсэж байна.

“Үндэсний эрх” сонин ба “Соёлын тэмцэл”-д өөрийн хувийн чинээгээр зохиосон “Уран авьяастан”, “Тэргүүний үеийн удирдагчид” хэмээх хоёр жижиг шүлэг мэтийг явуулав.

Хүрмэгц хүлээн аваад хэвлэлд тавьж өгөхийг эрхэмлэн хүсэхийн гадна буруу зөв алдаа осолтой зүйлүүдийг гүн оюунаа дусал болгон засварлаж өгөхийг хүсэж байна. Тэрчлэн хот орны сонин болоод шинэ гарсан ном дэвтрээр шагнах хайрлахыг дахин хүснэм.

Буяннэмэх! Таны явуулсан алтан захидлыг хүлээн авч шагнан хайрласан тоот төгрөг, эдгээрийг хүлээж аваад магнай хагартал гүнээ баярласныг хэлэх бүр уяралтай сайхныг юун дурдах ажээ. Энэ мэтчилэн алдар гавьяат улсын уран зохиолчдоос өчүүхэн намайг сурган хүмүүжүүлэх биз ээ хэмээн дахин гуйж хариу захидлыг гүнээ хүсэхийн гадна сургуулийн байдлыг илчилсэн өчүүхэн зурвасыг явуулав.

Хүндэт нөхөд аргагүй сонинд гаргаж хязгаар орны сургуулийн байдлыг сайжруулахыг хүснэ. Мөн “Үндэсний эрх”-ийн 81 дүгээрт бичсэн манай сургуулийн байдал болон өчүүхэний зохиолыг бичиж ирүүлсэнд давхар халуун баярыг хүргэж Улсын алдарт гавьяат уран зохиолч Буяннэмэх, Аюуш нарын амрыг эрэгч өчүүхэн дүү чинь үнэн. Хариуг их хүснэм”³ хэмээн Ховд аймгийн

³ Оюунбадрах Д. 2002. Пүрэвийн Хорлоо. XX зууны монгол зохиолчид-5.



Манхан сумаас 1935 оны 11-р сард захидал илгээж байсан юм. Эл бяцхан захидлаас П.Хорлоо хэдий үеийн хүн болох, хэзээ зохиол бүтээлээ бичиж, хэнтэй хэрхэн харьцаж байв гэх зэрэг олон зүйлийг харж болно.

1936 оны 03 дугаар сарын 07-нд хуралдсан “Монголын үндэсний уран зохиолчдын холбооны” бүх гишүүдийн хурал дээр дарга С.Буяннэмэхийн тавьсан илтгэлд: “... 1934 оныг хүртэл жүжгийн зохиолыг 8 хүн, үлгэр өгүүллэгийг 4-5 хүн, шүлгийг цөөвтөр хүн оролдож байсан бол 1936 оны байдлаар жүжгийн зохиолыг 25, шүлгийг 20, үргэлжилсэн үгийн зохиолыг 40 орчим хүн оролдож”⁴ байна гэжээ. Энд дурдсан шүлгийн 20 болоод үргэлжилсэн үгийн 40 хүний нэг нь Пүрэвийн Хорлоо юм. Тэр бээр ийнхүү анхлан шүлэг, дууны үг, бэсрэг өгүүллэгээр эхэлж улмаар найраглал, тууж бичих болсон бөгөөд 1960-аад оноос эхлэн жүжиг бичиж эхэлсэн юм. Энэ тухай дор дэлгэрүүлье.

II. Сурган хүмүүжлийн үзэл санаа бүхий тайзны зохиол, бүтээл

Зохиолч П.Хорлоо бүтээл туурвилаа уран бүтээлийн олон төрлөөр бичсэн бөгөөд тэр дундаас хүүхдийн уран зохиолын бүтээлүүд нь онцгой байр суурийг эзэлнэ. XX зууны Монголын хүүхдийн уран зохиолын нэлээд учир дутагдалтай гэж хэлж болох төрөл нь тайз, дэлгэцийн бүтээл бөгөөд энэ төрлөөр мэргэшсэн зохиолч өнөөг хүртэл тийм ч олон байсангүй. XX зууны хүүхдийн болон хүүхэлдэйн театрын урын сангийн дийлэнх хэсгийг орчуулгын жүжиг эзэлж, 1960-аад оныг хүртэл хүүхдийн кино

Ерөнхий редактор Х.Сампилдэндэв. Уб., 16-17

⁴ Монгол орчин үеийн уран зохиолын түүх. 1985. Тэргүүн боть. Редактор Ц.Дамдинсүрэн. Уб., 63



байгаагүй нь үүний илэрхийлэл бөгөөд зохиолч П.Хорлоо энэ үед өөрийн тайз, дэлгэцийн бүтээлүүдээ туурвиж эхэлсэн нь энэхүү орон зайг нөхөх алхам байсан юм. Зохиолчийн урын санд “Алтан үст охин” (1966), “Дахин уулзсан нь” (1967), “Шидэт толь” (1967), “Тулгаа” /Өрсөлдөөн/ (1969), “Тэмүүлэл” (1978), “Илгээлтийн эзэн” (1982), “Эрдмийн гайхамшиг” (1982) зэрэг жүжиг бий.

Зохиолчийн эдгээр жүжгүүдийг ерөнхийд нь авч үзвэл бидний өмнө өгүүлсэнчлэн Монгол аман зохиолын уламжлалыг ашигласан байх нь элбэг. “Туулайн бүжин” өгүүллэгийг 1960-аад оны үед Улсын Хүүхэлдэйн Театрын уран бүтээлчид жүжиг болгон тоглосон нь олны талархлыг хүлээсэн юм. *“Шударга, ариун сэтгэлтэй Туулайн бүжингийн дүр нэгэн үеийн бяцхан үзэгчдийн сэтгэлд хоногшин үлдсэн билээ. Түүгээр ч үл барам эл жүжиг тухайн цаг үеийн хот хөдөөгийн сургуулиудад ажиллаж байсан хүүхэлдэйн сайн дурын бүлгэмүүдийн бараг ганц урдаа барьдаг жүжиг нь болж, Ч.Ойдовын “Алиа Тогмид” лугаа эн зэрэгцэж байсан юм”*⁵. Ийнхүү аман зохиол тэр дундаа үлгэрийн зохиомж ашиглан бичсэн бүтээлийн нэг жишээ нь “Алтан үст охин” жүжиг болно. Ардын үлгэрийн үйл явдал дээр зохиолчийн уран сэтгэмжийн гайхамшигт боломжийг чадамгай нэгтгэн, сонин адал явдал бүхий жүжиг зохиожээ. Зохиолч өөрөө аман зохиолч судлаач учраас аман зохиол, уран зохиол хоёрын хэмжээ дамжааг нь тааруулсан хэмээн судлаачид үнэлсэн нь бий.

Алтан үсний ид шидийн тухай сюжет бусад орны аман зохиол болон уран зохиолд нэлээд тохиолддог. Жишээлбэл:

⁵ Оюунбадрах Д. 2002. Пүрэвийн Хорлоо. XX зууны монгол зохиолчид-5. Ерөнхий редактор Х.Сампилдэндэв. Уб., 39



Германы романтизмын нэрт төлөөлөгч Гофманы “Өчүүхэн Цахес” зохиолд ер бусын хүчний бэлгэдэл болсон шидэт алтан үсний тухай гардаг.

Тус жүжгийн зохиолын уран сайхны гол онцлог нь бодит амьдрал ба үлгэрийн үйл явдал хоёрыг урнаар хослуулж бичсэнд оршино. Үйл явдал нь Балбар хааны түшмэл Халтар нь хоньчин өвгөн Саруулын сахиуснаас алтан үс ч юм уу, утас ч юм уу нэг юм олж ирсэн бодит амьдралаар эхэлнэ. Алтан үсний эзэн Саруул өвгөн хүртэл өөрөө итгэхгүй, “*Алтай үстэй хүүхэн энэ орчлонд ганцхан байдаг юм гэнэ гэж үлгэр сонссоноос биш, өөр юмгүй, ноёнтон минь*”⁶ гэдэг бол хүү Итгэл нь ч “Энэ чинь үлгэр шүү дээ” гэснээр цаашдын үйл явдал өрнөнө.

Жүжигт харгис, шунахай Балбар ноён, түүний туслах Халтар нарын эсрэг шударга ариун үйлсийн төлөө тэмцэгч хоньчин хүү Итгэл, түүний найз Цэцгэнхүү, Навчинхүү нарын үнэнч, бат зузаан үерхэл, алтан үст Оюуномин охиныг аюулт мангасын гараас аварч өвгөн буурал эцэг Итгэлээ харгис ноёны хар гэрээс чөлөөлсөн тухай өгүүлдэг.

Зохиолын гол баатар болох хоньчин хүү Итгэл, Алтан үст охин зэрэг бол үлгэрийн баатрууд, харин Навчинхүү, Цэцгэнхүү нар бол үлгэрийн дүрслэлийн аргаар бүтээгдсэн уран сайхны дүр, Балбар ноён, Халтар түшмэл нар амьдралд байдаг хүмүүс гэх зэргээр энэ жүжгийн зөвхөн дүрүүдийг авч үзэхэд л зохиолчийн ухаан бодол, ур чадвараа уралдуулсан их хөдөлмөрийн үр дүн болох нь аяндаа илэрхий. Түүнчлэн Оюуномин:

⁶ Хорлоо П. 1970. *Тулгаа*. Жүжгийн зохиолууд. Уб., 120



“Ой модны тайрдас

Уран бугын шандас

Барим оосортой

Дэлэм суртай

*Тэр юу вэ?”*⁷ хэмээн Балбар ноёноор оньсого таалган Цэцгэн хүүдээ “ташуур” болохыг ойлгуулахад түүнийг мэдсэн Цэцгэнхүү:

“Морин замд айлтай юу?

*Модон хөтөлтөд устай юу?”*⁸ гэх зэргээр асууж сураглаж мөнөөх ташуурыг олж ирж байгаа, Балбар ноён өөрийн хүслээ:

“Араараа дүүрэн

Арван живаа

Адуутай болно

Өврөөрөө дүүрэн

Үй түмэн

Үхэр, хоньтой болно

Авдар авдраар

*Алт мөнгөтэй болно”*⁹ гэх зэргээр илэрхийлж байгаа, жүжгийн гол баатрууд аян замдаа:

“Барс явсан замаар

Туулай дэгдэж өнгөрнө

Баатар туулсан замаар

*Хүүхэд явж гарна”*¹⁰ хэмээн дуулж буй зэрэг нь цөм Монгол аман зохиолын хэл, зохиомж юм. Зохиолч энэ тухайгаа “*Үлгэрийн ийм мянган хэлхээс, түмэн үйл явдлыг жүжиг болговол*

⁷ Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 156

⁸ Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 160

⁹ Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 150

¹⁰ Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 132



тун сонирхолтой болно гэж бодогдов. Ард түмэн үлгэрийг бүтээхдээ хүний шударга үнэнч сэтгэл, шударга биш худалч хуурамч сэтгэлийг ялж байгаа бодит байдлыг гаргадаг болохоор Оюуноминг шударга үнэний амьдрал дундаас олж, Балбар ноёныг ховдог шунахай, харгис үзэлтний давхаргаас олж гол баатрууд болгон тэдний учрал тохиолдлыг ардын үлгэрийн ид шидийн аргаар гаргасан нь жинхэнэ үлгэрийн жүжиг болох эх нь тавигдсан даа” хэмээн бичжээ.

Зохиолд дүрийн тодорхойлолтыг хаалтанд хийж, эхлээд хувцсыг нь, дараа нь зан төлөвийг нь бичсэн байдаг. Тухайлбал: Балбар ноёныг “... хөмсөг зангидаж, нүүрээ атируулсан, догшин авиртай, урт хар хөмсөгтэй, ов тов цоохор өвгөн. Царайд нь ширүүн догшин авир илхэн. Жартгай хянуур нүдэнд нь ховдог шунахай байдал илэрхий. Нуруу дунд, гэдэс цүндгэр, хурдан хөдөлгөөнтэй, алхаж гишгэх нь хөнгөн, дуу шингэхэн бөгөөд чанга чанга хашгиран бачимдах мөртөө зальтай”¹¹ гэсэн бол Халтар түшмэлийг “Нүд бүлтгэр, хамар нахиу, хавчиг нарийхан нүүрэнд нь заль мэхтэй овжин байдал ил. Албан хүчээр инээмсэглэн байдаг нь бялдууч, зусарч шинж бүрэн”¹² хэмээн дүрсэлжээ. Харин Оюуномин охин бол “*Баргил хан уултай, Байцат цагаан нууртай, Баяндалай өвгөний арван охины хамгийн отгон*” бөгөөд алтан үснээсээ болж, арван таван толгойт мангасынд олзлогдоод, дахин Балбар хаанд очих болсон. Тэрээр өөрийгөө “*Нялх балчир байхад минь есөн шид бүрдсэн охин юм гэж олон хаад ноёд булаацалдсаар арван таван толгойт Атгаалжин хар мангас дийлж, энд авчирч хорьсон юм. Түүнээс*

¹¹ Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 116

¹² Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 115



хойш нар салхи, навч цэцгийн бараа харалгүй арван найман насыг хурлээ”¹³ гэдэг. Гэвч Итгэл хүү хоёр найзынхаа тусламжтайгаар түүнийг ард олонтой учруулж, олон түмнийг жаргуулж байна. Жүжигт Итгэл хүү “Асуух нэр алдар, ахлах эцэг эхгүй юм гэж бодов уу? Надад нэрлэх сайхан эцэг байна. Бахархах сайхан нутаг байна” гэж хэлэх “Энэ догшин цоохор нумыг гурав эвшээлгээд, тэр харагдаж байгаа тэвнийн сүвэгчээр оруулж, цаана нь байгаа бул хар чулууг бут үсэртэл нь оно” хэмээн болзол тавьж буй зэрэг нь эл зохиолын хэл нь аман зохиолын хэлэнд ойр болсныг гэрчилнэ.

Түүнчлэн П.Хорлоогийн жүжгүүдээс “Тулгаа” (1969) буюу “Өрсөлдөөн” жүжиг нь Улсын драмын театрт тавигдсан алдартай жүжиг бөгөөд 1930-аад оны үед хөдөө нутагт ардын сургууль байгуулж байгаа болон тухайн үед ямар саад бэрхшээл тохиолдож буйг харуулсан жүжиг юм. Зохиолын гол зөрчил бол шинэ хуучны зөрчил. Тэр үеийн монголд шарын шашны нөлөө их, монгол эрчүүдийн ихэнх хувь нь лам болсон байсан тул ардын засгийн зүгээс ядуу лам нарыг хар болгох, лам хүүхдүүдээс ардын сургуульд элсүүлэн, монгол бичиг заах явдал чухал байв. Мөн 1926 оны 09 дүгээр сарын 03-ны Шашин төрийг тусгаарлах хуулийг таниулж байсан түүхийн эгзэгтэй үеийг зохиолд тусгасан байна.

Тулгаа багш хүчтэй эсэргүүцэлтэй тулгаран зодуулж шархдаж байж, хийдийн дэргэд зоригтой ухуулга хийснээр олон лам нар хар болон, лам хүүхдүүд сургуульд орсныг ядуу лам Ням болон Цогт хүүгийн дүрээр харуулжээ. Лам нар шавиа алдахгүйн

¹³ Хорлоо П. 1970. Алтан үст охин. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 144



тулд ардын сургуультай өрсөлддөг. Тэднээс сургууль барьсан дэнжийг “... *буруу харсан амны тосгуур хар дэнж. Үүгээр хий юмны гүйдэлтэй газар*”¹⁴ гэдэг нь олон хүнд нөлөөлдөг. Мөн лам хүүхдүүд сургуулийн хүүхдүүдтэй зодолдож гэрийг нь нураана. Хаймчиг оточ орос докторын нэр хүндийг унагахын тулд Тулгаа багш болон осор хүүд хортой эм өгснөөс осор хүү амиа алддаг зэрэг гарз хохирол их тохиолдож байна. Лам нарын зүгээс шавь хүүхдээ зарцлан, өлөн зэлмэн явуулж, дураараа зодож дарамталдаг хэмээн зохиолд дүрсэлсэн байна. Зохиолч өөрөө 1927 онд Хан хөгшин уулын хошууны тэнхимд орж суралцан, улмаар Багшийн сургууль төгсөөд, 1934 оноос багшилж байсан тул тэр үеийн сургууль танхимын амьд гэрч байсан нь энэхүү жүжигтэй холбоотой биз ээ.

Энэ жүжгийн дүрүүдийг авч үзье. Багшийн сургууль төгссөн залуу багш Тулгаа танхимын даргаар ирж байна. Тэрээр өрнүүн сэтгэлтэй аливаа саад бэрхшээлийг даван туулах сэтгэлийн тэнхээтэй хүн. Лам хүүхдүүдийг сургуульд татахын тул эелдэг харьцан, ухуулга хийж олон хүнийг хар болгодог. Түүнтэй хамт ажилладаг Сандаг бол Мангал тайжийн хүү бөгөөд зугаа цэнгэл эрхэлсэн хүн. Бэрхшээл саадаас шантран, ардын хүүхдийг зодох зэргээр зохисгүй ааш гаргадаг.

Хаймчиг оточ бол өнгөн дээрээ тусч дүр үзүүлээд, цаагуураа хорлодог хоёр нүүртэй хүн сургууль байгуулахад эсгий үүрч ирснээр Тулгаа багшийн өмнө сайн хүн болж харагддаг. Дамиран түүнийг “*Олив оготно шиг элдэвтэй хүн*”¹⁵ гэдэг нь энэ дүрийг бүрэн тодорхойлсон гэж болно. Тэрээр том толгойт,

¹⁴ Хорлоо П. 1970. *Тулгаа*. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 12

¹⁵ Хорлоо П. 1970. *Тулгаа*. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 23



Жамбаа нарыг ашиглан хорлох ажиллагаа явуулдаг. *“Шашин бурхантай газар очвол хамаг жаргал ирнэ”*¹⁶ хэмээн ардуудад дүрвэж нүүхийг ятгадаг. Хортой эм өгөхөөс гадна сургуулийн барьж буй байшинг шатаах гэж яваад баригдаж байна. Том толгойтыг Тулгаа багшид муулсан мөртөө өөрөө ашиглаж байдаг, Цогтыг алдахгүйн тул солиотой хүүхэд хэмээн Тулгаа багшид ойлгуулдаг зэрэг нь түүнийг уран аргатай хүн болохыг гэрчилнэ. Энэ мэт дүр бүр өөр өөрийн онцлог шинжтэй байх бөгөөд жүжгийн зохиомж үйл явдалд цөм чухал үүрэг гүйцэтгэсэн нь ажиглагдаж байна.

Зохиолд бас нэг өвөрмөц дүрслэл байдаг нь “Бядан явагч бялзуухайн бичиг”-ийн тухай дүрслэл юм. Түүн дээр эхлээд хийдийн гэсгүй ламын, дараа нь Сандаг багшийн тухай бичигдсэнийг тэдний зүгээс Бялзуухай хочтой, хошууны тамгын зарлага Дамдинг хэмээн андуурдаг. Дамдин эхлээд айж хэлмэгдэж байсныг Тулгаа нар зоригжуулж байна. *“Энэхүү жүжиг нь зарим дүр, дүрслэлээрээ ижил сэдэв бүхий зохиолуудтай Ч.Лодойдамбын “Манай сургуулийнхан”-тай төстэй боловч 1930-аад оны үеийн Монголын түүхийн тулгамдсан асуудлыг жүжгийн зохиолд тусгасан сайн зохиол болсон юм. Харин 1970 онд хэвлэгдсэн зохиолоос харахад 3, 4-р бүлгийн завсар орхигдсон дүрслэл байж магадгүй баймаар байна. Гуравдугаар бүлгийн төгсгөлд Тулгаа багш оргосон хүүхдийн хойноос явсны араас Тоомой хүүхнийг авах санаатай Сандаг хардан хойноос нь явдаг. Энд “Сэрэлт” кинон дээр маарамба орос докторын морийг үргээдэг шиг нэлээн зөрчил үүсмээр*

¹⁶ Хорлоо П. 1970. *Тулгаа*. Тулгаа (жүжгийн зохиолууд). Уб., 29



*байсан боловч дараагийн бүлэгт ямар ч тайлал байхгүй, бүх юм зүгээр байгаагаар эхэлдэг*¹⁷.

“Шидэт толь” жүжигт бол гол баатар Товуудай хүү “Хүний жаргах хүсэл, дэлгэрэх мөрөөдөл хэзээ нэг цагт биелж, ноён зарц ялгаагүй тэгш болох юм шүү”¹⁸ хэмээн ард түмний мөрөөдлийн санааг илэрхийлж, Долоодой өвгөний хүү ямаачин Товуудай алс явж, эрдмийг сураад “санасныг бүтээж, жаргалыг эдлүүлдэг” шидэт толь олохоор хэцүү аянд явна. Олон саад бэрхшээлийг даван явсаар толийг олж, харгис Цэнгэл ноёныг устган, ард олноо жаргуулдаг. Энд Цэнгэл ноён Барс хүүтэйгээ толийг булаалдан, бие биеэ хардаж, улмаар ноён хүүгээ хөнөөж буйгаар эрх мэдэл эд баялгийн төлөө хүн чанараа гээж, улайран тэмцэгчдийг харуулжээ.

Энэ мэтээр монгол баатарлаг туулиас сэдэвлэсэн “Бум Эрдэнэ”, үлгэрийн өгүүлэмж, дүрслэлийг ашиглан Монгол, Оросын ард түмний өнө эртний уламжлалт найрамдлын харилцаа, хоёр орны ард түмний эрх чөлөөний тэмцлийн тухай өгүүлсэн “Шидэт толь” зэрэг жүжиг нь зөвхөн хүүхдүүд төдийгүй нийт үзэгчдийн таашаалыг хүртсэн байна. Дээр өгүүлсэнчлэн П.Хорлоогийн бичих дуртай сургууль, багш нарын амьдралаас сэдэвлэсэн “Тулгаа”, “Дахин уулзсан нь” жүжгүүдэд хувьсгалын эхэн үед зөвхөн ном, эрдэм хүүхдэд заах үүрэгтэй төдийгүй ард олныг ухааруулан сэнхрүүлж, эсэргүү дайсны хорт явуулгын эсрэг тэмцэх зэрэг өргөн үүрэг хүлээн гүйцэтгэж байсан манай

